



АЗИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАРОМЕТР

Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол
мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ



АЗИЙН
ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
БАРОМЕТР

МОНГОЛ УЛС 2012

FRIEDRICH
EBERT 
STIFTUNG



АЗИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАРОМЕТР

Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол
мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ

МОНГОЛ УЛС 2012

Published by:

Фридрих-Эбертийн Сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газар
Төв шуудан ш/х 831
Улаанбаатар хот-210648 Монгол Улс
Утас: +976-11-312892
Факс: +976-11-312889
Майл хаяг: oyun@fesmongol.net

© Friedrich-Ebert-Stiftung (FES)

ISBN

No. 978-99973-50-11-4

The sale or commercial use of all media published by the Friedrich-Ebert-Stiftung (FES) is prohibited without the written consent of the FES.

The findings, interpretations and conclusions expressed in this volume do not necessarily reflect the views of the Friedrich-Ebert-Stiftung or fesmedia Asia. fesmedia Asia does not guarantee the accuracy of the data included in this work.

АГУУЛГА

ОРШИЛ 5

ТОВЧ ТОЙМ 9

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: 15

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг (хэвлэлийн эрх чөлөөг хамруулан) үр дүнтэйгээр хамгаалан дэмждэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: 31

Хэвлэл мэдээллийн салбар олон талт, хараат бус, тогтвортой байдлаар тодорхойлогдож байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: 45

Өргөн нэвтрүүлгийг ил тод, хараат бус байдлаар зохицуулдаг. Төрийн мэдлийн радио телевизийг жинхэнэ утгаар нь олон нийтийн радио телевиз болгон өөрчилж чадсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: 59

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэргэжлийн хэм хэмжээг хангахуйц өндөр түвшинд ажилладаг.

ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД 71

ХАВСРАЛТ 76

Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн тухай (АХМБ)

Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн тухай (АХМБ)

Азийн Хэвлэл Мэдээллийн Барометр нь Ази дахь улс орны хэвлэл мэдээллийн орчин нөхцөлд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, цогцоор нь үнэлэх тогтолцоо юм. Ингэхдээ тухайн орны мэргэжилтнүүд хэвлэлийн эрх чөлөөний олон улсын стандартыг ашиглан өөрийн үнэлгээ хийдгээрээ хэвлэл мэдээллийн байдлын талаарх бусад судалгаа, дүгнэлтээс ялгаатай.

Түүнчлэн Азийн Хэвлэл Мэдээллийн Барометр нь хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэх нөлөөллийн арга хэрэгсэл болж өгдөгөөрөө онцлог юм. Өөрөөр хэлбэл үнэлгээний тайланг олон нийтэд танилцуулж, хэвлэл мэдээллийн байдлыг олон улсын шалгуур үзүүлэлтэд хүргэхийн тулд тухайн оронд бодлогын ямар өөрчлөлт шаардлагатайг таниулахад ашиглах боломжтой. Тийм ч учраас эдгээр мэдээллийг Фридрих Эбертийн Сан (ФЭС) болон холбогдох түнш байгууллагууд нь үйл ажиллагааныхаа бодлого, хөтөлбөрт тусгаж ажилладаг.

Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн загвар болон арга барилыг Африкийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн аргачлалд суурилан боловсруулсан юм. Ингэхдээ “Африкт үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөгжүүлэхэд баримтлах зарчим” зэрэг тунхаг бичиг, гэрээ хэлэлцээрийн зарчим, үзэл санаанаас урган гарах шалгуур үзүүлэлтийг ашигласан болно. 2005 оноос хойш Африкийн Хэвлэл Мэдээллийн Барометрийг Африкийн 28 улсад 70 гаруй удаа хоёроос гурван жилийн давтамжтайгаар зохион байгууллаа. Улмаар ФЭС тухайн улс дахь түншлэгч байгууллагуудтайгаа хамтран хэвлэл мэдээллийн байдалд урт хугацааны дүн шинжилгээ хийж, үр дүнг нь хэвлэл мэдээллийн шинэчлэлийг дэмжих үйл ажиллагаанд үр бүтээлтэйгээр ашиглаж ирсэн билээ.

Харин Азид байдал өөр байна. Өмнөд Азийн хэд хэдэн оронд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэлийн эрх чөлөөний шалгуур үзүүлэлт, тунхаг бичгийг бие даан боловсруулах оролдлогыг хийжээ. Эдгээрийг аль нэг оронд амжилттай хэрэгжүүлж чадаагүй ч, хэд хэдэн орны хэмжээнд, зарим үед бүр бүсийн хэмжээнд ашигласан туршлага байна. Харин Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хариуцсан тусгай илтгэгчийн 2006 оны тунхаг бичигт болон бүсийн зарим байгууллагаас гаргасан мэдээлэлд Ази Номхон далайн бүс нутагт ийм арга хэрэгсэл үгүйлэгдэж буйг тэмдэглэсэн байдаг.¹

1 Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх олон улсын баримт бичиг, НҮБ-ын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай илтгэгч Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай илтгэгч, Америк (муж) Улсуудын Байгууллагын (ОАС) үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай илтгэгч, Африкийн хүний эрхийн комиссын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай илтгэгч нарын хамтран гаргасан мэдэгдэл, 19.12.2011, <http://www.article19.org/data/files/pdfs/igo-documents/four-mandates-dec-2006.pdf>.

Азид үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх бүс нутгийн хэмжээний тунхаг бичиг үгүйлэгдэж буйг засгийн газрууд хэвлэлийн эрх чөлөөг боомилох, мэдээлэл авах иргэдийн эрх чөлөөг хязгаарлах далим болгон ашиглах ёсгүй билээ. Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлд баталгаажуулсан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, "мэдээлэл болон үзэл санааг хайх, хүлээн авах, бусдад түгээх" эрх чөлөө нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орон бүрт хамаатай. Үүнийг 2011 оны долдугаар сард НҮБ-ын Хүний эрхийн комиссоос гаргасан Ерөнхий тайлбар бичгээр баталгаажуулж, хэвлэлийн эрх чөлөөг дэмжин хөгжүүлэх орчин нөхцлийг бий болгох зөвлөмжийг төрийн удирдагчдад өгсөн билээ.²

Тийм учраас Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрт ашигласан олон улсын шалгуур үзүүлэлтүүд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын шийдвэр гаргах түвшинд баталгаажсан болно.

Ази тивд гарсан хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой, сайн дураар дагаж мөрдөх зарчмыг багтаасан цорын ганц баримт бичиг бол "Мэдээлэл, Өргөн Нэвтрүүлгийн Бангкокийн Тунхаг" (2003) юм³. Энэхүү баримт бичгийн хүрээнд Ази, Номхон далайн бүс нутгийн мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн салбарыг хариуцсан сайд нар болон өргөн нэвтрүүлгийн байгууллагын удирдлага, судлаач, бодлого боловсруулагч болон олон улсын байгууллагын төлөөлөгчид мэдээлэл авах эрх чөлөө, өргөн нэвтрүүлгийн эрх зүйн зохицуулалттай холбоотой зөвлөмжийг хэлэлцэн баталж, гарын үсэг зурсан билээ.

Уг баримт бичгийг батлах олон улсын хурлыг Ази, Номхон Далайн Өргөн Нэвтрүүлгийн Хөгжлийн Хүрээлэнгээс зохион байгуулсан бөгөөд уг хурлыг Олон Улсын Харилцаа Холбооны Хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллага, ЮНЕСКО, Франц улсын засгийн газар болон ФЭС идэвхтэйгээр дэмжиж, хамтран ажилласан юм. Уг хурлаас баталсан мэдээлэл авах, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг олон нийтийн статустай болгож өөрчлөхтэй холбоотой зөвлөмжийн үзэл санааг Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийн шалгуур үзүүлэлтэд тусгасан болно.

ФЭС-ын Ази дахь хэвлэл мэдээллийн хөтөлбөрөөс Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийг Энэтхэг болон Пакистан (2009), Тайланд (2010) болон Филиппинд (2011) амжилттай зохион байгуулсныхаа туршлагад үндэслэн Азийн бусад олон оронд, жишээлбэл Монгол улс (2012), Пакистан (2012) болон Энэтхэгт (2013) хэвлэл мэдээллийн байдлын ажиглалт, үнэлгээ хийж, хэвлэл мэдээллийн шинэчлэлийг дэмжин ажиллах болсон юм.

ФЭС-ын Ази дахь хэвлэл мэдээллийн хөтөлбөрөөс Азийн Хэвлэл Мэдээллийн Барометрийг Энэтхэг, Пакистан (2009), Тайланд (2010) болон Филиппинд (2011) амжилттай зохион байгуулсан туршлага дээрээ үндэслэн Азийн бусад олон оронд хэвлэл мэдээллийн байдалд ажиглалт, үнэлгээ хийж, хэвлэл мэдээллийн шинэчлэлийг дэмжин ажиллах болсон юм.

2 Хүний эрхийн комисс, Нэг зуун хоёр дахь хуралдаан, Ерөнхий тайлбар Др. 34, 19-р зүйл: Үг хэлэх, үзэл бодол илэрхийлэх эрх чөлөө, Женев, 2011 оны 7 сарын 11-29, <http://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>(мэдээллийг 10.11.2011 татаж авав).

3 Бүтэн эхийг <http://www.aibd.org.my/node/693>(2011.10.11).

Аргачлал: Хоёроос гурван жил тутамд нэг удаа хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад болон иргэний нийгмийн таваас доошгүй, таван төлөөллөөс бүрдсэн мэргэжилтний бүлэг уулзаж өөрийн орны хэвлэл мэдээллийн байдалд үнэлгээ өгнө. Тэд хоёр өдрийн туршид хэвлэл мэдээллийн байдал үндэсний хэмжээнд ямар буйг 45 шалгуур үзүүлэлтийн дагуу хэлэлцэж, шалгуур тус бүрт нэгээс тав хүртэлх оноо өгнө. Шалгуур үзүүлэлтийг олон улсын улс төрийн гэрээ хэлэлцээр, тунхаг бичигт үндэслэн боловсруулсан бөгөөд тэдгээр нь байвал зохих дээд түвшин буюу зорилгыг илэрхийлдэг.

Хэлэлцүүлэг болон үнэлгээний үйл явцыг ФЭС-аас дадлагажуулан сургасан мэргэжилтэн удирдан явуулдаг бөгөөд тэрээр мөн тухайн орны тайланг хянан тохиолдуулах үүргийг хүлээнэ.

Үнэлгээний тогтолцоо: Шалгуур тус бүрийг хэлэлцсэний дараа хэлэлцүүлэгт оролцсон хүн бүр тухайн шалгуур ямархуу түвшинд хангагдаж буйг үнэлж оноо тавих бөгөөд оноо өгөх үйл явц нууцаар явагдана. Оноог дараах шатлалаар өгнө:

1	Шалгуурыг огт хангахгүй байна	
2	Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна	
3	Шалгуурыг зарим талаар хангаж байна	
4	Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна	
5	Шалгуурыг бүхий л талаар хангаж байна	

Өөрөөр хэлбэл шалгуурыг огт хангахгүй байвал 1 (нэг) оноо өгнө. Хэрэв тухайн орон шалгуурыг бүхий л талаар хангаж байвал 5 (таван) оноо өгөх бөгөөд энэ нь өгч болох хамгийн өндөр оноо юм.

Хэлэлцүүлэгт оролцогчдын өгсөн онооны нийлбэрийг оноо өгсөн хүний тоонд хувааж дундаж үзүүлэлтийг гаргана. Салбар тус бүрийн дундаж онооны нийлбэрийг салбарын тоонд хувааж, тухайн орны дундаж үзүүлэлтийг тооцоолно.

Үр дүн: Хэлэлцүүлгийн ерөнхий агуулга болон шалгуур тус бүрийн үзүүлэлтийг онооны задаргаа болон тухайн орны дундаж онооны хамт чанарын шинжтэй эцсийн тайланд тусгана. Хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийг аливаа хэлбэрийн дарамт шахалтаас хамгаалах үүднээс тэдний хэлсэн зүйлсийг нэр дурьдан ишлэхгүй. Ийнхүү хоёроос гурван жил тутамд гаргах тайлан нь тухайн орны хэвлэл мэдээллийн хөгжлийн түвшинг үнэлж, хэвлэл мэдээллийн бодлогын шинэчлэлийн үндэс суурь нь болох учиртай юм.

**Фридрих-Эбертийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газрын
Захирал Чогдонгийн Оюунгэрэл**

**Фридрих-Эбертийн сангийн
хэвлэл мэдээллийн бүсийн
төслийн захирал
Фридрих-Эбертийн сангийн
Шри Ланка, Малдив улсыг
хариуцсан захирал Нора
Лангенбахер**

АЗИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАРОМЕТР МОНГОЛ УЛС 2012

ТОВЧ ТОЙМ

Монгол Улс Азийн анхны социалист орны хувьд нэг намын ноёрхол, үзэл суртлын дарангуйллын 70 жилийн түүхтэй. Гэсэн хэдий ч богино хугацаанд ардчилсан нийгмийн үндэс суурийг тавьж, эдүгээ хүний эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөний шалгуур үзүүлэлтүүдээр Азид дээгүүр ордог орон болжээ.

Ардчилсан тогтолцоонд шилжсэний дараахан буюу 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиар иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталж, 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно” хэмээн тунхагласан. Уг хуулиар мөн төрийн байгууллага мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглож, төрөөс олон нийтийн мэдээлэлд хяналт буюу цензур тавихгүй байхаар тогтсон билээ. Улмаар Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг 2005 онд баталснаар засгийн газрын эзэмшилд байсан үндэсний хэмжээний радио, телевизийг олон нийтийн статуст шилжүүлэн хөгжүүлэх үйл явц эхэлсэн юм. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөг эрх зүйн хувьд бататгасан өөр нэгэн чухал алхмыг 2011 онд хийсэн нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан явдал байв. Энэхүү хуулиар төрийн болон төсвөөс санхүүждэг байгууллагын ил тод байдлыг хангах, иргэн, хуулийн этгээд эдгээр байгууллагаас мэдээлэл авах үйл явцыг зохицуулсан юм.

Ийнхүү үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэлийн эрх, эрх чөлөөг эрх зүйн хувьд харьцангуй өндөр түвшинд баталгаажуулсан хэдий ч, эдгээр эрхийг бодит амьдралд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай. Юуны түрүүнд дээрх хуулиудын үйлчлэх хүрээг хязгаарладаг, мөн зөрчилддөг эрх зүйн баримт бичиг нэлээд буйг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал бамэдээлэл авах эрхийн тухай хуулийн бүрэлдэхүүн хэсэгт 1995 онд батлагдсан Төрийн нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хууль хамаардаг. Гэтэл нууцын тухай эдгээр хууль нь маш өргөн хүрээний мэдээллийг нууцлах боломж олгодог учир төрийн албан хаагчид эдгээр хуулиар халхавч хийн мэдээлэл өгөхөөс татгалзах боломж нээлттэй байсаар байна.

1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглосон хэдий ч, өмнө нь буюу 1993 онд батлагдсан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34-р зүйлд

“Хот радио, телевиз, сонин, сэтгүүлтэй байж болно” хэмээн заасныг эдүгээг хүртэл өөрчлөөгүй байна. Тиймээс орон нутгийн засаг захиргаанаас сонин хэвлэл эрхлэн гаргах, радио телевизийг өөрийн ивээлд авч ажиллуулах явдал үргэлжилсээр. Нэгэнт төрийн мэдээллийн хэрэгслийг зөвшөөрсөн эсэх нь тодорхойгүй учир төрийн байгууллагын харьяанд ажиллаж буй мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан зохицуулалт байдаггүй, тийм учраас төрөөс санхүүжиж, төрд харъяалагдаж буй хэвлэл мэдээллийн байгууллагууд бүгд төр, түүний аль нэг байгууллагыг сурталчлах үүргийг хүлээж байна.

Редакцийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын хувьд зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулинд ийм заалт байдаг. Гэсэн хэдий ч энэхүү байгууллагын удирдлагын томилгоонд улс төрийн нөлөөлөл хүчтэй байдгаас уг байгууллагын редакцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх сонирхол илт харагддаг.

Редакцийн хараат бус байдлыг эрх зүйн хувьд баталгаажуулах шаардлага хэрэгцээ Монголын хэвлэл мэдээллийн салбарын нэн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Учир нь улс төр, бизнесийн томоохон төлөөлөгчид хэвлэл мэдээллийн салбарт хөрөнгө оруулах нь сүүлийн жилүүдэд нэмэгдэж, улмаар өөрийн эзэмшлийн мэдээллийн хэрэгслийг үзэл суртал, бизнесийн сурталчилгаа, нөлөөллийн хэрэгсэл болгон ашиглах хандлага түгээмэл байна. Эзэд, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд бичигдээгүй хууль болоод буй учир сэтгүүлчдийн шударга, тэнцвэртэй, нягт нямбай ажиллах зарчим алдагдаж, хэвлэл мэдээллийн нэр хүнд, итгэл үнэмшил буурч байна.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, түгээх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулж буй өөр нэг зүйл бол нууц эх сурвалжаа хамгаалахыг эрх зүйн хувьд баталгаажуулаагүй явдал юм. Нийгэмд буй аливаа зөрчил, доголдол, нуугдмал ашиг сонирхлыг илрүүлж, нийтэд мэдээлэхэд нэрээ нууцлахыг хүссэн эрх сурвалжууд чухал үүрэгтэй. Гэвч ийм мэдээлэл нийтийн хүртээл болсон тохиолдолд шүүх, цагдаа сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардаж, дарамталдаг учир иргэд ч, сэтгүүлчид ч эрх мэдэлтнүүдтэй холбоотой зөрчилтэй мэдээллийг түгээхээс болгоомжилж заншаад байна.

Бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор гүтгэх, доромжлохыг Монголд эрүүгийн гэмт хэрэг хэмээн үзэж, эрүүгийн хуулийн дагуу торгох, баривчлах шийтгэл ногдуулдаг. Үүний улмаас иргэд, сэтгүүлчид өөрийгөө байнга цагдан хянахад хүрч байна.

Ийнхүү иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлага хэрэгцээ байгаа хэдий ч ардчилал, зах зээлд шилжсэнээс хойш иргэдийн мэдээлэл авах боломж эрс нэмэгдсэнийг дурьдах хэрэгтэй. Уламжлалт мэдээллийн хэрэгслийн хувьд 2012 оны эхний сарын байдлаар Монголд 460 гаруй мэдээллийн хэрэгсэл (120 гаруй сонин, 90 сэтгүүл, 150 гаруй телевиз, 70 гаруй радио) үйл ажиллагаа

явуулж, төрөл бүрийн мэдээллээр иргэдийг хангаж байна. Хот, хөдөөгийн хооронд иргэдийн мэдээлэл авах боломж нэлээд зөрүүтэй. Монгол Улсын өргөн уудам газар нутаг, хүн ам цөөн, нягтрал бага, дэд бүтэц сул, жижиг мэдээллийн хэрэгслийг дэмжих төрийн ямар нэг бодлого байдаггүй учир орон нутгийн мэдээллийн хэрэгслийн тархалтын хүрээ, нэвтрүүлгийн цаг болон борлуулалтын хувь хэмжээ маш бага.

Харин хот, суурийн газрын иргэдийн хувьд дээр дурдсан олон төрлийн уламжлалт мэдээллийн хэрэгслээс гадна Интернет мэдээллийн чухал эх сурвалж болж байна. Монгол Улсын Засгийн газраас 2005 – 2012 онд хэрэгжүүлсэн “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд улс орныг хамарсан нийтэд хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах зорилго тавьж ажилласны хүчинд 329 сумдаас 170 гаруй нь Интернетийн сүлжээтэй болсон.

Интернэтийн хэрэглээг Засгийн газрын зүгээс хязгаарлах ямар нэгэн оролдлого хийж байгаагүй бөгөөд харин 3000-аас дээш хандалт бүхий сайтуудыг албан ёсны бүртгэлд хамруулах, тэдгээр сайтад гарч буй сэтгэгдлийн IP хаягийг ил болгох, зүй бус үг хэллэгийг шүүх шүүлтүүр тавих зэрэг шаардлагыг тавьж байна.

Гар утасны хэрэглээ Монгол Улсад маш өндөр байна. 2006 – 2011 онд гар утас хэрэглэгчдийн тоо 721,000-аас 2.75 сая болж өссөн байдаг бөгөөд хэрэглээний хувьд хот, хөдөөгийн ялгаа бараг үгүй. Гагцхүү гар утасны сүлжээ зөвхөн суурин газрыг хамардаг учир хөдөө алслагдмал амьдарч буй өрхүүд гар утасны үйлчилгээг авахын тулд аль нэг суурин газар, эс бөгөөд өндөрлөг газрыг бараадах шаардлагатай болдог.

Хэвлэл мэдээллийн салбарт гарч буй харьцангуй шинэ үзэгдэл бол хэвлэл мэдээллийн байгууллагууд цөөн эзэмшигчийн гарт төвлөрөх хандлага юм. Төвлөрлийн цар хүрээ одоогоор харьцангуй бага байна гэж үзэх үндэслэл байгаа хэдий ч, хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч, хөрөнгө оруулагчдын ил тод бус байдал нь төвлөрлийн хэмжээг бодитоор дүгнэх боломжгүй болгож байна. Одоогоор олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжих, төвлөрлийг сааруулах эрх зүйн ямар нэгэн зохицуулалт Монголд байхгүй.

Хот, хөдөөгийн иргэдийн аль алиных нь хувьд хамгийн түгээмэл ашигладаг мэдээллийн хэрэгсэл бол телевиз. Магад тийм ч учраас эрх баригчдын зүгээс өргөн нэвтрүүлгийн салбарыг хянах хүсэл сонирхол өндөр байгаа нь дараах баримтаас харагдана.

Өргөн нэвтрүүлгийн асуудлыг хариуцсан газар буюу Харилцааны холбооны зохицуулах хорооны дарга, гишүүдийг Засгийн газраас томилдог. Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олголт ил тод бус, улс төрийн нөлөөлөл өндөр байдаг. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл, дарга нарын томилгоо мөн л ил тод бус, улс төрийн шийдлээр явагддаг. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд эрх барьж буй намын төлөөлөл давамгайлдаг. Олон

нийтийн радио, телевизийн тухай хуулиар тус байгууллагын редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан хэдий ч бодит амьдралд улс төрийн нөлөөлөл байсаар байна. Харин хөтөлбөрийн бүтцийн хувьд өргөн нэвтрүүлгийн уг байгууллага арилжааны телевизүүдтэй харьцуулбал илүү олон талт агуулгыг нийгмийн янз бүрийн бүлэгт хүргэж чадаж байгаа билээ.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын мэргэжлийн түвшин дорой байна. Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийн хүрээнд, мөн Хэвлэлийн Хүрээлэн, Глоб Интернэшнл зэрэг төрийнбус байгууллагуудаас сэтгүүлчдэд зориулсан олон төрлийн сургалтыг байнга зохион байгуулдаг ч редакцийн оновчгүй бүтэц зохион байгуулалт, хэвлэл мэдээллийн удирдах ажилтнуудын орчин үеийн менежмент, хүний нөөцийн бодлогын тухай мэдлэг сул байдаг тул сэтгүүлчдэд тэдгээр боломжийг ашиглах, сурсан зүйлээ өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэх боломж хомс байна. Нөгөө талаар сэтгүүлчдийн цалин, нийгмийн хамгаалал сул байдгаас тэд авилгын янз бүрийн хэлбэрт өртөмтгий, сэтгүүлзүйн үнэт зүйл, хэвлэл мэдээллийн итгэл үнэмшлийг хамгаалахаасаа илүү хувиараа орлого олох боломж бүрийг алдалгүй ашиглахыг хичээж байна.

Сэтгүүлзүйн ёсзүйн дүрмийг сэтгүүлчдийн байгууллагаас ч, хэвлэл мэдээллийн зарим байгууллага өөрсдөө ч баталсан байдаг боловч хэрэгждэггүй. Учир нь тэдгээр дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо байдаггүй. Өөрийн зохицуулалтын байгууллага хэрэгтэй гэдэгтэй салбарынхан санал нэгддэг боловч ашиг сонирхлын зөрчил, ойлголтын зөрүү, мөн хэвлэл мэдээллийн төлөвшиж гүйцээгүй тогтолцоо өөрөө үүнд саад болж байна. 2012 онд УИХ-д Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хэвлэлийн консул байгуулах асуудлыг хуульчлах санал дэвшүүлсэн бөгөөдийм байгууллага байгуулах цаг нь болсон учир хуульчилсан нь дээр гэж олон хүн үзэж буй хэдий ч эргэлзэж, болгоомжилж буй хүн ч цөөнгүй байна.

Ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш Монгол Улсад иргэний нийгэм хүчтэй төлөвшиж буй нь иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөөг хөгжүүлэн бэхжүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Хэвлэл мэдээллийн салбарын хууль, эрх зүйн баримт бичгийг боловсруулахад өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх нь ерөнхийдөө хэвшил болоод байгаа бөгөөд үүнд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцож, саналаа дэвшүүлдэг. Гэхдээ хэвлэлийн эрх чөлөөг тууштай хамгаалж, олон ургальч хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг цөөн хэдэн байгууллага байдаг. Иргэний нийгмийн бусад байгууллага хэвлэлийн эрх чөлөөний үнэ цэнэ, нөхцөл байдлын талаар ойлголт багатай, тийм ч учраас үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үйлсэд төдийлөн идэвхтэй оролцдоггүй.

Товчлон дүгнэвэл, Монголын хэвлэл мэдээлэл эрх зүйн хувьд харьцангуй либерал орчинд, барууны хэвлэл мэдээллийн загвар, үнэт зүйлсийг удирдамж болгон хөгжиж байгаа бөгөөд иргэдэд мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх өргөн боломж нээлттэй байна. Гэсэн хэдий ч хэвлэлийн эрх чөлөөг тууштай

бэхжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл дутмаг байгаагийн улмаас сэтгүүлчид айдас, болгоомжлол, улс төр, бизнесийн хөндлөнгийн хүчтэй нөлөөллийн дор өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж , сэтгүүлзүйн чанар, хэвлэл мэдээлэлд итгэх итгэл үнэмшил буурсаар байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх
эрх чөлөөг (хэвлэлийн эрх чөлөөг
хамруулан) үр дүнтэйгээр хамгаалан
дэмждэг.

Нэгдүгээр бүлэг: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг (хэвлэлийн эрх чөлөөг хамруулан) үр дүнтэйгээр хамгаалан дэмждэг.

1.1 Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг (хэвлэлийн эрх чөлөөг хамруулан) Үндсэн хуулиар баталгаажуулж, хууль эрх зүйн бусад зохицуулалтаар дэмждэг.

“цаасан дээр бол Монгол Улсын иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй.”

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд

“Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: ...итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.”

17 дугаар зүйлд “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан байдаг.

Түүнчлэн 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хоёрдугаар зүйлд Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосноос гадна уг хуулийн гуравдугаар зүйлээр цензурыг хориглосон билээ. Мөн хуулийн дөрөвдүгээр зүйлд төрийн байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглосон.

Өөрөөр хэлбэл хууль эрх зүйн хүрээнд буюу цаасан дээр бол Монгол Улсын иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй гэж ойлгож болохоор байдаг. Гэвч бодит байдалд Үндсэн хуульд туссан бэлгэ тэмдгийн чанартай заалтаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бүрэн хангагдаж чадахгүй байна. Учир нь Монгол Улсын хувьд төрийн, хувь хүний, албан байгууллагын нууцын тухай хуулийн заалтууд маш өргөн хүрээг хамарч, тодорхойгүй байдлаар томъёологдсон байдаг. Тиймээс нууцын тухай хуулиудыг Монголд хэтрүүлэн хэрэглэх нь түгээмэл.

1995 онд батлагдсан Байгууллагын нууцын тухай хуулийн Тавдугаар зүйлийн


1-д “Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө” гэсэн байдаг. Аль ч байгууллага нууцын ангилалд оруулах зүйлсээ өөрийн жагсаалтаар гаргах боломжтой тул бүх мэдээллээ нууцлах сонирхолтой байдаг. Энэ талаарх нэмэлт мэдээллийг нууцын тухай хуультай холбоотой 1.3 дугаар шалгуур үзүүлэлтээс харна уу.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Хот сонин, сэтгүүл, радио, телевизтэй байж болно”, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 5 дугаар хэсэгт “Хот, тосгон өөрийн мэдлийн радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ” гэсэн байдаг. Өөрийн мэдлийн мэдээллийн хэрэгсэлтэй байх тухай энэхүү заалт нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 4–р зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэсэн заалттай зөрчилдсөөр байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.6

1.2 Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэрэгждэг бөгөөд иргэд ба сэтгүүлчид уг эрхээ айдасгүйгээр хэрэгжүүлдэг.

“Дараа нь
намайг
хамгаалах
хүчтэй
байгууллага
байхгүй”

Монголын иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдэлж, эрх мэдэлтнүүдийг улам бүр чөлөөтэй шүүмжилж буй боловч хөдөөгийн иргэд төв суурин газрынхнаас харьцангуй илүү бэрхшээл саадтай учирч байна.

Уудам нутагт тархан суурьшсан цөөн хүн амтай онцлогоосоо болоод жижиг суурин газрын иргэд орон нутгийн удирдлагаасаа шууд хамааралтай амьдардаг. Малчдын дунд ерөнхийдөө төрийн албан хаагчдын өмнө хүлцэнгүй дуулгавартай байх уламжлал тогтсон. Нийгмийн хамгаалал зэрэг төрийн бүх үйлчилгээг харъяалагдах орон нутгийн даргаасаа авдаг учир айдас нь социализмын үеийн айдсаас хадгалагдаж ирсэн инерци байж болох юм гэж хэлэлцүүлгийн оролцогчид үзэж байна.

**“сэтгүүлчид
тууштай
байж чадвал
ямар нэгэн
байдлаар
бүтээлээ
нийтэлж,
нэвтрүүлэх
арга зам
олддог.”**

Төрийн зарим албан хаагч шүүмжлэл хэлсэн иргэдийг заналхийлэх тохиолдол гардаг. Үүний нэг жишээг Монголд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн төлөөлөгч дурдав. Тэрхүү байгууллагын төлөөлөл Дундговь аймагт иргэдийн дунд нээлттэй утас ажиллуулж, иргэд нь удирдлагадаа асуулт тавьж, шүүмжлэх зүйлсээ шууд утсаар хэлж байсан аж. Дундговь аймагт халаалтгүй байгаа хөлдүү газрын тухай нэгэн иргэн шүүмжлэхэд албан тушаалтан тухайн хүнийг дуугаар нь таниад загнаж байх жишээтэй.

Ийм бэрхшээл сэтгүүлчдэд ч түгээмэл тохиолддог. Жишээлбэл Дархан хотын сэтгүүлч мэргэжлийн хяналтын байгууллагын байцаагчийг шүүмжилж бичсэнийхээ төлөө тус байгууллагаас мэдээлэл авах боломжоо хязгаарлуулжээ. Мөннэг сэтгүүлч Дархан хотын Хуримын ордны хувьчлалын асуудлыг хөндөхөөр 3 жил хөөцөлдсөний эцэст аймгийн Засаг дарга хууль бус хувьчлалтай холбоотой гэсэн таамгийг дэвшүүлжээ.

Гэвч нотлох баримтыг олж авч чадаагүй учраас мухардалд орж энэ сэдвийн талаар цаашид эрэн сурвалжлах боломжгүй болсон аж.

Глоб интернэшнл ТББ-ын 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр мэдээ, улс төр, нийгмийн чиглэлээр идэвхтэй ажилладаг сэтгүүлчдийн дунд хийсэн судалгаагаар⁴ тэдний айдаст автдаг хамгийн ноцтой шалтгаан нь “Дараа нь намайг хамгаалах хүчтэй байгууллага байхгүй”-д оршдог гэжээ. Псевдоним хэрэглэж, нэрээ нууцалж байгаа нь болгоомжлолын нэг хэлбэр. Энэ нь нэг талаар социализмын үеийн айдсын үлдэгдэл боловч нөгөө талаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг болон хэвлэлийн эрх чөлөөг эрх зүйн хувьд баталгаажуулаагүйтэй холбоотой. Болгоомжилсны улмаас сэтгүүлч өөрийн ажил, бүтээлдээ өөрийгөө цагдан хянаж эхэлдэг.


Сэтгүүлчид эрхээ хэрхэн хамгаалахаа мэддэггүй нь байдлыг улам хүндрүүлдэг. Тухайлбал, нэгэн телевизийн сэтгүүлч шинэ нэвтрүүлэг бэлтгэж гурван дугаар гаргасны дараа тэр нь хаагдсан жишээ бий. Яагаад хаагдав гэхээр “дээрээс хаах үүрэг өгсөн” гэж хэлтсийн дарга нар хариулдаг. “Дээрээс” гэдэг үгийг хэн ч цааш нь лавлаж тодруулдаггүй бөгөөд ийм тохиолдолд ерөнхийдөө бэлтгэлтэй байдаг аж. Ийм үед арай өөр нэвтрүүлэг гаргах замаар асуудлыг шийдэх Монголын арга байдаг талаар тухайн сэтгүүлч ярьсан юм. Санал, шүүмжлэлийг илэрхийлэхдээ сэтгүүлчид ерөнхийдөө иргэдээс илүү айдастай байдаг. Харин бусдад найрсаг хандах уламжлалт сэтгэлгээ нь сэтгүүлчдийн ч, иргэдийн ч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна.

4 Сонгуулийн үеэр Монголын сэтгүүлчид хэрхэн ажилласан бэ. Ардчилсан сонгууль ба хэвлэл эдээлэл төсөл. Глоб Интернэшнл, ЮНЕСКО 2004 он <http://www.globeinter.org.mn/?cmd=Content&id=26&menuid=65>

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.5

1.3 Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хууль, хуулийн тодорхой заалт байхгүй. Нууцыг хамгаалах, бусдын нэр хүндэд халдахын эсрэг болон гүтгэлгийн эсрэг хуулийн хэт өргөн хүрээг хамарсан заалтаас үүдэлтэй зохисгүй арга хэлбэрээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох явдал гардаггүй.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой, хэвлэлийн эрх чөлөөг санаатай болон санамсаргүйгээр хязгаарлаж буй 50 гаруй хууль бий. Эдгээрээс дор хаяж 15 нь бүхлээрээ, эсхүл зарим хэсэг нь албан ёсны нууцтай холбоотой байдаг.

Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улсад төрийн нууцад хамааруулах мэдээллийн хүрээг Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологий, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд тогтоох тухай заасан байдаг. Эдгээр чиглэлийн яг ямар мэдээлэл, баримт бичгийг төрийн нууцад хамааруулахыг “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулийн дагуу баталдаг боловч тодорхой тогтсон, ил тод зарчим байдаггүй. Мэдээллийг төрийн нууцад хамааруулахдаа удирдлага болгох үндсэн шалгуурыг “хуульд нийцсэн байх, цаг үеэ олсон байх” хэмээн маш ерөнхий тодорхойлсон байдгаас гадна мэдээллийг нууцлах эрх бүхий этгээдийг хоёрдмол утгатайгаар хуульчилсан нь Төрийн нууцын тухай хуулийг хэт өргөн хүрээнд ашиглах боломжийг нээж өгдөг. Жишээлбэл, Төрийн нууцын тухай хуулийн дагуу УИХ төрийн нууцын жагсаалтыг батлах ёстой боловч мөн хуулийн дагуу Тагнуулын Ерөнхий Газар “шаардлагатай бол” ямар ч мэдээлэл, эд зүйл, баримт бичгийг “онц чухал - маш нууц” зэрэглэлд хамруулж нууцлах эрхтэй байдаг.

Эрүүгийн хуулийн 87.1-д "Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задрүүлсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан. Түүнчлэн Батлан хамгаалахын тухай хуулийн дагуу улс орны хүнс болон цэвэр усны хангамжтай холбоотой мэдээллийг ил болгохыг хориглодог.

Жирийн иргэний хувийн нууцыг хамгаалдаггүй мөртлөө байгууллагын нууцыг маш хатуу хамгаалдаг, албан байгууллагад илүү тааламжтай эрх зүйн орчин Монголд үйлчилдэг. "Миний төрсөн өдрөөр улс төрчөөс бэлэг ирсэн. Хувийн мэдээллийг маань хаанаас авсан бэ, хувийн нууц хуулийн дагуу бас л хамгаалагдах ёстой" гэж төрийн бус байгууллагын төлөөлөл энд жишээ татав.

Эдгээр болон бусад хуулийг идэвхтэйгээр хэрэгжүүлдэггүй боловч нэг л өдөр эрх мэдэлтнүүд ашиглах боломж нээлттэй байна.

*"хувийн нууц
хуулийн
дагуу бас л
хамгаалагдах
ёстой"*

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 оны 6 дугаар сард баталсан боловч уг хуульд нийцүүлж бусад хуульдаа өөрчлөлт хийгээгүй. Уг хуулийн 2.1-р зүйлд "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Хувь хүний нууцын тухай энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ" гэж заасан. Өөрөөр хэлбэл одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Нууцын тухай багц хууль нь Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн салшгүй нэг хэсгийн хувьд уг хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлах хүчин зүйл нь болсоор байна.


Гүтгэлэг доромжлолыг эрүүгийн хэрэгт тооцдог хэвээр байна. 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн 110.1 дүгээр зүйлд "Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. хэмээн заасан байдаг.

1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хоёр дугаар зүйлд хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах хууль тогтоомж гаргахыг хориглосон боловч хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй дээр дурьдсан болон бусад хуульд холбогдох өөрчлөлтийг оруулаагүй байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.3

1.4 Засгийн газар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэлийн эрх чөлөөг хангахад ашиглаж болох бүс нутгийн болон олон улсын бүх хэрэгслийг ашиглахын тулд өөрөөс шалтгаалах бүхнийг хийдэг.

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зарчмуудыг хүлээн зөвшөөрч, 1976 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орсон билээ. Дээрх хоёр баримт бичгийн 19-р зүйлд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллийг хилийн зааг ялгаагүйгээр аливаа арга хэрэгслээр хүлээн авах, эрж, сурвалжлах эрх чөлөөтэй хэмээн заасан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төр засаг нь олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, дээр заасан эрхийг баталгаажуулан хамгаалах үүрэгтэй.


Монгол Улс хүлээн зөвшөөрсөн НҮБ-ын Конвенцийн тоогоороо дэлхийд дээгүүр ордог. Харин тэдгээр Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлдэггүй нь бодит байдлаас харагддаг.

Хэдийгээр Монгол Улс дээр дурьдсан эрхийг 1992 оны Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрч, 16 дугаар зүйлээр баталгаажуулсан боловч харамсалтай нь, иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөө өнөөг хүртэл тунхаг төдий байсаар байна. Иргэний болон улс төрийн эрхийн пактын 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийн тайланг 4 жилд нэг удаа гаргаж өгөх ёстой байтал Монголын Засгийн газар 7 жилийн дараа НҮБ-ын Хүний эрхийн хороогоор хэлэлцүүлжээ. Засгийн газрын болон төрийн бус байгууллагуудын гаргасан тайлан агуулгын хувьд хоорондоо их зөрдөг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.0

1.5 Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл хэвлэн нийтлэхийн тулд төрийн зөвшөөрөл авах шаардлагагүй.

“Бүртгэл тухайн албан тушаалтны үзэмжээс хамаардаг.”


Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг хуулийн бусад этгээдийн нэгэн адил бүртгүүлэх шаардлагатай байдаг. Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг бүртгэхийн тулд Улсын бүртгэлийн газраас тухайн хэвлэн нийтлэгчээс шаардаж буй олон зүйлсийн дотор хэвлэх үйлдвэртэй байгуулсан гэрээ хоёр хувь, эдийн засгийн тооцоо гэх мэт бүртгүүлэх хүсэлтийг хянаад зөвшөөрөл олгох гэж байгаа мэт хатуу шаардлагууд багтдаг. Хэлэлцүүлэгт оролцогчид бүртгэлтэй холбоотой шаардлагуудыг хэрхэн үзэх талаар санал зөрөлдөж байв. Зарим нь бүртгэлийн регистрийн дугаар өгөх зорилготой л материал шаардаж буйг тэмдэглэж байсан бөгөөд хэсэг мэтгэлцсэний эцэст оролцогчдын ихэнх нь бүртгэх үйл

явц тухайн албан тушаалтны үзэмжээс хамаардаг бөгөөд татгалзах, эсвэл зөвшөөрөх сонголт нээлттэй байна гэж үзэв. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагыг бүртгэхдээ хуулийн бусад этгээдээс ялгавартай, тусгай шаардлагууд тавьж байгаа нь бүртгэлийн журмаа хэтрүүлэн хэрэглэж буй явдал гэж оролцогчид үзлээ. Зүй ёсоор бол хэвлэл мэдээллийн байгууллагыг бусад аж ахуйн нэгжийн адилаар Аж ахуйн нэгжийн тухай хуулиар л бүртгэх ёстой гэв.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.5

1.6 Сэтгүүлч мэргэжлээр ажиллахад ямар нэг хуулийн хязгаарлалт байхгүй


Сэтгүүлзүйн салбарт ажиллахад хуулийн хязгаарлалт байхгүй.

Монголын хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй хүмүүсийн тал орчим хувь нь сэтгүүлч мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байдаг. Гэхдээ сэтгүүлчээр ажиллах хүсэлтэй хүмүүст заавал мэргэжил эзэмших, аль нэг байгууллагын зөвшөөрөл авах зэрэг шаардлага байдаггүй бөгөөд тийм хууль журам ч байдаггүй.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.9

1.7 Мэдээллийн нууц эх сурвалжийг хуулиар, эсхүл шүүхээр хамгаалдаг.


Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах тухай хуулийн ерөнхий зохицуулалт байхгүй. Зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 34 дүгээр зүйлийн хоёрдугаарт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” хэмээн заасан байдаг боловч энэхүү заалт нь олон нийтийн радио телевизийн ажилтнуудаас бусад хүнд хамааралгүй юм. Харин олон нийтийн радио, телевизийн сэтгүүлчид хуулиар олгосон дээрх эрхээ төдийлөн ашиглахгүй байна.

Монголын Сэтгүүлчдийн Эвлэлээс 2012 онд шинэчлэн баталсан ёс зүйн дүрэмд нууц эх сурвалжаа хамгаалах тухай заалт бий боловч энэхүү зарчим нь эрх зүйн чадамжгүй. Шүүхийн практикт эх сурвалжаа илчлэх нь өөрийгөө хамгаалах арга мөн хэмээн сэтгүүлчдэд хэлэх, шахалт үзүүлэх тохиолдол нэлээд гардаг. Гүтгэлгийн эсрэг хэрэг үүсгэсэн хүмүүс өөрийгөө хамгаалахын тулд эх сурвалжийг илчлүүлэх зорилгоор тийнхүү шүүхэд хандах нь олонтаа. Парламентын гишүүд болон бизнес эрхлэгчид сэтгүүлчээр эх сурвалжийг нь хэлүүлэхийн тулд заналхийлэх явдал ч түгээмэл байдаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.8

1.8 Төрийн байгууллагын мэдэлд буй мэдээллийг хялбар аргаар олж авах боломж бүх иргэнд нээлттэй бөгөөд мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулсан байдаг.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 оны зургаадугаар сард баталсан билээ. Уг хуулийн 6 дугаар бүлгийн нэгдүгээр зүйлийн дагуу үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахыг хуульчилж өгсөн. Энэхүү ил тод байдлыг хангахын тулд холбогдох байгууллагууд дурьдсан мэдээллийг цахим хуудсандаа байршуулах ёстой.

Хуулийн 11 дүгээр зүйлийн нэгдүгээр хэсэгт иргэн, хуулийн этгээд “хуулиар хориглосноос бусад” мэдээллийг хүлээн авах эрхтэйг заасан бол хуулийн 2 дугаар бүлгийн нэгдүгээр зүйлд Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай болон Хувийн нууцын тухай хууль Мэдээллийн ил тод байдал, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулинд хамаарахгүйг тодотгосон байдаг. Түүнчлэн 18 – 21 дүгээр зүйлд мэдээллийн ил тод байдалд хамаарахгүй бусад тохиолдлыг, жишээлбэл “тухайн мэдээллийг олон нийтэд түгээснээр үндэсний аюулгүй байдал, олон нийтийн ашиг сонирхолд хор уршиг учруулах нь тогтоогдох” зэрэг тохиолдлыг зааж өгсөн байна. Хуулийн зүйл заалтыг биелүүлээгүй албан хаагчдыг торгох, захиргааны бусад шийтгэл оноох эсхүл ажлаас халах хүртэлх арга хэмжээ авахаар тогтоожээ (25 дугаар зүйл).


Энэхүү хуулийг ерөнхийдөө сайн хууль хэмээн үздэг ч үндсэндээ хэрэгждэггүй. Хуулийг хэрэгжүүлэх хоёр журам гарах ёстой ч өнөө хэр гараагүй байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ч уг хуулийн хэрэгжилтийг нэхэж шаардахгүй байна. Ялангуяа төсвийн задаргаа, дэлгэрэнгүй мэдээллийг олж авахад ихээхэн хүндрэлтэй. Хүний нөөц болон худалдан авалтын төсөвтэй холбоотой мэдээллийг ил болгохоос татгалздаг. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 1-р сарын 18-ны өдрийн 17-р тогтоолын хавсралтаар “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ы баталсан боловч бодит байдал дээр төсвөө ил тод мэдээлдэг төрийн байгууллага байхгүй хэвээрээ. Төрийн байгууллагуудын цахим хуудас ч тогтмол шинэчлэгддэггүй. “Өөрийгөө сурталчлах чиглэлийн мэдээллийг төрийн байгууллагууд сэтгүүлчдэд өгдөг. Харин байгууллагын шийдвэрүүд, төсвийн задаргаа, дэлгэрэнгүй мэдээллийг ил гаргадаггүй” хэмээн нэгэн оролцогч дурьдав. Хэлэлцүүлгийн үеэр төрийн мэдээллийг ашиглах соёл сэтгүүлчдэд төдийгүй иргэдэд дутагдаж байгаа талаар мөн онцлон дурьдаж байв. Өвөрхангай аймгийн Гучин-Ес, Хэнтий аймгийн Баянхутаг суманд сумын захиргаа нь самбар дээр бүх мэдээллээ ил тавьчихсан байхад түүнийг ашиглах дадал сумын иргэдэд суугаагүйгээс лавлаж асуусаар байдаг жишээг нэгэн оролцогч дурьдлаа. Монголчууд нүүр нүүрээ харж байж асууж, хариултаа авч заншсан улс учир мэдээлэл хайх, хүлээн авах шинэ арга боломжийн талаарх иргэний боловсролыг дээшлүүлэх шаардлагатай байгааг хэлэлцүүлэгт оролцогчид онцлов.

*“мэдээлэл хайх,
хүлээн авах
шинэ арга
боломжийн
талаарх
иргэний
боловсролыг
дээшлүүлэх
шаардлагатай”*

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.9

1.9 Цахим хуудас, блогийг төрийн байгууллагад бүртгүүлэх эсхүл улсын зөвшөөрөл авах шаардлагагүй.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос 2011 онд гаргасан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий шаардлага” хэмээх журмын дагуу олон нийтэд мэдээлэл түгээх болон арилжааны зориулалттай, өдөрт 3000-аас дээш хандалт бүхий цахим хуудсыг 2011 оны хавраас эхлэн бүртгэдэг болсон. Хэлэлцүүлэгт оролцогчид үүнийг нэг ёсны зөвшөөрөл олгож буй хэрэг хэмээн үзэж байна. Харин Харилцаа Холбооны Зохицуулах Хороо нь “Хүчирхийлэл, садар самуун, терроризмд уриалан дуудахаас сэргийлэх зорилгоор хийж буй хаягийн бүртгэл” хэмээн тодрууллаа. Цахим хуудсыг бүртгүүлэх шаардлагатай эсэхийн талаар ийнхүү санал зөрчилдөж буйн дээр бүртгүүлэх журам нь олон талаар эргэлзээ төрүүлдэг аж. Тухайлбал цахим хуудас, блогийн ялгааг уг журмаар гаргаж зохицуулдаггүй, хандалтын тоог харвал блог ч бүртгүүлэх хэрэгтэй болдог. Байгууллагын цахим хуудасны хандалт өдөрт 3000-аас дээш гарвал яах вэ гэх мэт асуудлууд ч урган гардаг байна.

“өдөрт 3000-аас дээш хандалт бүхий цахим хуудсыг 2011 оны хавраас эхлэн бүртгэдэг болсон.”


Цахим мэдээлэл эрхлэгчид өөрсдөө сайн дураараа бүртгүүлдэг. ХХЗХ-оос авсан статистикаар өдөрт 3000-аас дээш хандалттай 60 орчим цахим хуудас бий бөгөөд эдгээрээс 17 нь бүртгүүлсэн гэлээ.

2012 оны УИХ-ын сонгуулийн өмнө, хоёрдугаар сард Цагдаагийн Ерөнхий Газар дээр “төрийн эрхийг хууль бусаар авахыг завдахаас сэргийлэх зорилгоор” ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2012 оны долдугаар сарын 4 хүртэл буюу сонгуулийг дуустал ажиллаж, тавь гаруй сайтыг хянасан байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.6

1.10 Хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай хуулийн хязгаарлалтаас бусад тохиолдолд төрийн зүгээс Интернэтийн агуулгыг хаах, эсхүл хянах оролдлогыг хийдэггүй.

ХХЗХ-оос тавьж буй шаардлагын дагуу “зүй бус үг хэллэгийг” шүүх зориулалттай шүүлтүүрийн програмыг тус Хороонд бүртгүүлсэн бүх сайт ашиглах ёстой. Томоохонд тооцогддог сайтууд бүгд ийм шүүлтүүртэй. Харин хэлэлцүүлгийн нэг оролцогч “Тагнуулын Ерөнхий Газраас нэгэн сайтад бичлэг үлдээсэн хүний IP-г задлах, шалгах шаардлага тавьсан. Ерөнхийлөгч Н.Энхбаярыг ална гэж бичсэн учир” гэж мэдэгдлээ


Цахим хуудаст нэвтрэх эрхийг хаах боломж нь ХХЗХ-нд байдаг бол Тагнуулын Ерөнхий Газар эрх зүйн ямар нэгэн шат дамжлагагүйгээр аливаа сайтыг түр болон бүрмөсөн хаах эрх мэдэлтэй. ХХЗХ-оос эрхээ хэрэгжүүлж, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан шалтгаанаар нэг, Монгол Улсын болон олон улсын хөгжим, урлагийн болон тайз дэлгэцийн кино урлагийн бүтээлүүдийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр байршуулан нийтэд түгээж байгаа 16 цахим хуудсын үйл ажиллагааг 2012 оны 9 дүгээр сарын байдлаар зогсоогоод байна.

*“зүй бус үг хэллэгийг”
шүүх зориулалттай
шүүлтүүрийн
програмыг...
бүртгүүлсэн бүх
сайт ашиглах
ёстой.”*

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.4

1.11 Хэвлэлийн эрх чөлөөг иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ерөнхийд нь, мөн хэвлэл мэдээллийн сонирхлын бүлгүүдийн зүгээс идэвхтэй дэмждэг.

“Улс төрчид өөрийн “эзэмшлийн” төрийн бус байгууллага байгуулдаг...”

Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд хэвлэлийн эрх чөлөөний талаар ойлголт муу. Хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг цөөн төрийн бус байгууллага л асуудлыг ойлгож, хэвлэлийнхний бэрхшээлийг хуваалцдаг. Глоб Интернэшнл болон Хэвлэлийн Хүрээлэн зэрэг байгууллага хэвлэлийн эрх чөлөөний асуудлыг судалгаа, хурал зөвлөлгөөн сургалт, ном товхимол зэргээр дамжуулан сурталчилдаг.

Сонины Холбоо, Телевизүүдийн Холбоо зэрэг байгууллагууд нь эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалдаг бөгөөд хэвлэлийн эрх чөлөөний зарчмуудыг идэвхийлэн хамгаалах тал дээр сул. Сэтгүүлчдийн Эвлэлийн хувьд эзэмшигч болон сэтгүүлчдийг эгнээндээ нэгтгэдэг учир үүнээс үүдэлтэй сонирхлын зөрчил үйл ажиллагаанд нь саад болдог.


Монгол Улсын хуулиар хувь хүн шүүхэд хандах эрхтэй учир хэвлэл мэдээллийн эвсэл холбоод гишүүдийнхээ эрхийг болон хэвлэлийн эрх чөлөөг байгууллагын хувьд хамгаалах нь бэрхшээлтэй байдаг.

Түүнчлэн иргэний нийгмийн тухай ойлголт өөрөө Монголд ээдрээтэй. Энэ нь улс төр, бизнесийн ашиг сонирхлыг маш олон төрийн бус байгууллага дэмжиж ажиллагсаас гадна улс төрчид хувийнхаа зорилгыг биелүүлэх үүднээс өөрийн “эзэмшлийн” төрийн бус байгууллага байгуулдагтай холбоотой.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.7


1.12 Хэвлэл мэдээллийн салбарын хууль тогтоомжуудыг төрийн байгууллага, иргэд, сонирхлын бүлгүүдийн хоорондын зөвшилцлийн үр дүнд тогтоодог.

Хэвлэл мэдээллийн салбарын хууль тогтоомжийн төслийг хэлэлцэхэд төрийн бус байгууллагууд санаачлагатай ажилладаг. Жишээ нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг батлахад Глоб Интернэшнл ТББ-ын санаачлага (ФЭС-ийн дэмжлэгтэй) маш чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ хуулийг олон удаа хэлэлцүүлж байж батлуулсан билээ. 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөн олон дахиж хэлэлцсэн. Уг хуулийг өөрчлөх хоёр ч төсөл гарч ирсэн учир зөрүүтэй заалтуудыг өөрчлөх шийдлийг олох гэж иргэний нийгмийн байгууллагууд олон хэлэлцүүлэг өрнүүлсэн. Тийнхүү хэлэлцэх явцад Засгийн газраас өргөн барьсан, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах олон заалт бүхий хуулийн төслийг иргэний нийгмийнхэн нэлээд шүүмжилж байсан нь уг хуулийн төслийг өргөн барьсан байгууллага татаж авахад ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн байх талтай. Хэлэлцүүлгийн суурийг төрийн бус байгууллагууд тавих нь элбэг. 2001 оноос хойш мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгцээ шаардлагын талаар төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид мөн ихярьсан. Хуулийн төслийг УИХ-ын цахим хуудаст байршуулдаг бөгөөд хэлэлцүүлэг идэвхтэй өрнөж, санал маш их гардаг. Хуулийн хэлэлцүүлэгт Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Хэлэлцүүлгийг сайн хийдэг боловч харин хууль батлагдах үед хууль тогтоогчид дуртай хэсгээ аваад, дургүйгээ орхичихдог. Өөрөөр хэлбэл үр дүн бага байдаг. Хууль лоббидох явцад зарим заалтыг нь санаатайгаар авч хаядаг, заримыг нь гишүүд бүрэн мэдэхгүй, сайн ойлгоогүйгээсээ хасдаг. Жишээлбэл, харилцаа холбооны болон бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг 49 хувиас хэтрэхгүй байх заалтыг тухайн салбарынхан өөрсдөө мэдээгүй байхад баталсан байдаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.1

1 БҮЛГИЙН ДУНДАЖ ОНОО:

3.5

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

Хэвлэл мэдээллийн салбар олон
талт, хараат бус, тогтвортой байдлаар
тодорхойлогдож байна.

Хоёрдугаар бүлэг: Хэвлэл мэдээллийн салбар олон талт, хараат бус, тогтвортой байдлаар тодорхойлогдож байна.

2.1 Мэдээллийн олон төрлийн эх сурвалж (хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл, радио телевиз, Интернэт, гар утас) иргэдэд нээлттэй, үнэ төлбөр нь боломжийн байдаг.

Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл

2011 оны эцсийн байдлаар Монголд 126 сонин, үүнд өдөр тутмын 16, долоо хоног тутмын 30 сонин, мөн 92 сэтгүүл хэвлэгдэн гарч⁵ байсан бөгөөд сэтгүүлийн дийлэнх нь (40) улирал тутмынх байв. Сонины хувьд Улаанбаатар хотын 12 ба түүнээс дээш насны нийт хүн амын 14 хувь нь өдөр бүр сонин уншдаг бөгөөд эдгээрийн дийлэнх нь ажил эрхэлдэг, 30-аас дээш насны, дээд боловсролтой иргэд байна⁶. Сонины үнэ сүүлийн арван жилд 200 – 250 (0.14 - 0.18 ам доллар) төгрөгөөс 500-600 төгрөг (0.36 - 0.43 ам доллар) болж өсөн нэг ширхэг талхны үнэтэй ойртсон билээ. Олон хүн ийм хэмжээний зардлыг өдөр бүр гаргах боломжгүй болж, хувиараа сонин худалдан авахаас илүүтэйгээр ажлын байрандаа уншиж байна. Ялангуяа сонины идэвхтэй уншигч байсан, одоо тэтгэвэрт буй өндөр настуудад сонины үнийн өсөлт эмзэг туссан учраас хэдэн сонин зэрэг захиалах болон худалдан авах нь ховордсон байна.⁷ Сонин уншигчдын дийлэнх нь өдөр тутмын сонин уншдаг бөгөөд энэ төрлийн сонины борлуулалт 2011 онд өмнөх оноос 26 хувиар өссөн билээ. Өдөр тутмын 16 сонины тав нь өдөрт нийт 65000 хувиар борлогдож, сонины зах зээлийн 61 хувийг эзэлж байна. 65000 хувь ширхэг гэдэг бол 2.8 сая хүн амтай, 15 ба түүнээс дээш насны хүн амын 97,4 хувь нь бичиг үсэгт тайлагдсан улс орны хувьд харьцангуй бага үзүүлэлт байж болох юм.

Сэтгүүлийн үнэ нь сониныхоос өндөр боловч (долоо хоног тутмын сэтгүүл дунджаар 1000 төгрөг буюу 0,72 Ам доллар) борлуулалтын хэмжээ нь жил ирэх тусам нэмэгдсээр байна. Сэтгүүлийн зах зээлийн тал орчим хувийг телевизийн мэдээ, ахуйн зөвлөлгөө бүхий хөнгөн чанарын, 7 хоног тутмын сэтгүүл эзэлж буй. Ийм сэтгүүл уншигчдын дийлэнх нь буюу 77 хувь нь 12 – 29 насны хүүхэд, залуучууд байна⁸. Долоо хоног тутмын сэтгүүлийн нэг удаагийн нийт борлуулалт 74 мянга хувь ширхэгт хүрч байгаа билээ.

5 “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” 2012 оны тайлан, Хэвлэлийн Хүрээлэн, 2012 он, 2-р тал

6 Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн судалгааны тайлан 2012 оны 9 дүгээр сар, Хэвлэлийн Хүрээлэн

7 Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр, 16-р тал.

8 Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн судалгааны тайлан, Хэвлэлийн Хүрээлэн, 2012 оны 9 дүгээр сар.

2006 онд батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.14-ийн дагуу борлуулсан бүх сонинг НӨАТ-аас чөлөөлдөг.

Гэсэн хэдий ч сонины түгээлтийн тогтолцоо сул, хаягаар хүргэх систем нийслэл хотод ч, хөдөө орон нутагт ч байхгүйн улмаас сонины зах зээлийг өргөтгөх боломж хомс байна.

Өргөн нэвтрүүлэг

Монгол Улсад 2011 оны байдлаар үндэсний болон орон нутгийн 72 радио, 149 телевиз үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тухайн жилд 23 шинэ телевиз зах зээлд нэгджээ⁹. Нийт телевизийн 36 нь кабелийн үйлчилгээ үзүүлэгч оператор юм. Тухайлбал “Сансар” КаТВ-ээр 7000 төгрөг (5 Ам доллар) төлөөд 94 суваг үзэх боломжтой. Сүүлийн үед Интернэт, телевиз, холбооны багцалсан үйлчилгээ үзүүлэгч компаниуд хоорондоо хүчтэй өрсөлдөж эхлээд байна.

Монголд радио тийм ч түгээмэл мэдээллийн хэрэгсэл биш юм. Ялангуяа ФМ радиогийн хүртээмж бага бөгөөд ихэнхдээ зөвхөн суурин газар л сонсох боломжтой. Улаанбаатар хотын 12 ба түүнээс дээш насны хүн амын тал хувь нь радио огт сонсдоггүй, 17 хувь нь өдөр бүр сонсдог. Радиоог байнга сонсдог хүмүүсийн дийлэнх нь 30 – 39 насны хүмүүс бөгөөд голдуу машинд явж байхдаа радио сонсдог аж.

“Малчдын хувьд цаг агаар, үнэ ханшийн мэдээллийг гар утсаараа дамжуулан Интернэтээс авч байх хэрэгцээ шаардлага өндөр”

Интернэт

Интернэтийн хэрэглээ Монголд маш өндөр. Өндөр хурдны Интернэт ашиглалтын дэлхийн дундаж үзүүлэлт 30-35 хувь байдаг бол энэ үзүүлэлт Монголд 33 хувьтай гэж ХХЗХ тайлагнажээ¹⁰. “Цахим Монгол” хөтөлбөр амжилттай хэрэгжсэний үр дүнд Монголын нийт 329 сумын 168 нь өндөр хурдны Интернэттэй болсон. Гэхдээ өндөр хурдын сүлжээ татсан боловч орон нутагт Интернэтийн хэрэглээ төдийлөн хөгжихгүй байгаа бөгөөд харин Улаанбаатарт бол 12-оос дээш насны иргэдийн 63 хувь нь өдөр тутам Интернэт ашиглаж байгаа. Интернэтийн идэвхтэй хэрэглэгчдийн дийлэнх нь буюу 70 гаруй хувь нь 12 – 29 хүртэлх насны хүүхэд, залуучууд байна.

Гар утас

Гар утасны хэрэглээ Монголд маш өндөр. Гар утасны хэрэглээний дэлхийн дундаж 80 хувь байдаг бол Монголд энэ үзүүлэлт 120 хувь гэж гарчээ. Оператор компаниуд хямдрал, сугалаа, байр гэх мэтийг хэрэглэгчээ татах гэж байнга зарладаг. Өрсөлдөөний улмаас гар утасны үнэ ханш буурч байгаа. Гагцхүү гар утасны сүлжээ зөвхөн суурин газрыг хамардаг учир хөдөө алслагдмал газар амьдарч буй өрхүүд гар утасны үйлчилгээг авахын тулд аль нэг суурин газар,

9 Монголын Хэвлэл Мэдээлэл өнөөдөр” тайлан, хуудас 2


10 Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээ 2012 оны 5 сарын 17 <http://crc.gov.mn/file/setguul/CRCnewssecond.pdf>.

эс бөгөөд өндөрлөг газрыг бараадах шаардлагатай болдог. Ерөнхийдөө гар утсаар Интернэтэд нэвтрэх хандлага өсөж буйг дагаад харилцаа холбооны илүү боловсронгуй төхөөрөмжийн хэрэглээ нэмэгдэж байна. Малчдын хувьд цаг агаар, үнэ ханшийн мэдээллийг гар утсаараа дамжуулан Интернэтээс авч байх хэрэгцээ шаардлага өндөр буйг тэмдэглэх нь зүйтэй.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.7


2.2 Төрийн байгууллагуудын зүгээс иргэдийн дотоодын болон гадаадын хэвлэл мэдээллийг ашиглах боломжийг хязгаарладаггүй.

Монголчууд гадаадын мэдээллийг Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч 40 гаруй компани, кабелийн үйлчилгээ үзүүлэгч 36 оператор, үүрэн телефоны 5 компанийн сувгаар дамжуулж саадгүй хүлээн авах боломжтой бөгөөд гадаадаас ирэх мэдээллийн урсгалыг төрөөс хязгаарлах ородлого хийж байгаагүй.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

5.0

2.3 Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг түгээх, нэн ялангуяа хөдөө орон нутагт түгээлтийг сайжруулах хүчин чармайлтыг хийдэг.

Зарим алслагдмал газарт өдөр тутмын сонинг хүргэхийн тулд хоёр долоо хоног шаардагдах үе бий.

Шуудан захиалга, хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг 6 байгууллага одоогоор бүртгэлтэй байна. Эдгээрээс нэг нь буюу “Монгол шуудан” компани төрийн өмчит аж ахуй бөгөөд ноёрхох байр суурийг эзэлдэг. Сүүлийн жилүүдэд шуудан хүргэлтийн жижиг компаниудын тоо олшрох хандлагатай байгаа боловч тэдгээрийн аль нь ч “Монгол Шуудан”-тай өрсөлдөхүйц хэмжээнд хүрээгүй байна. Энэхүү байдлыг улс төрчид зүй бусаар ашиглаж буйг хэлэлцүүлгийн оролцогч тэмдэглээд, “УИХ-ын нэг гишүүн өөрийнх нь тухай шүүмжлэлтэй материал хэвлэгдсэн сонины бүх дугаарыг цагдаагийн тусламжтайгаар хурааж авсан” тухай ярьсан юм.

“УИХ-ын нэг гишүүн өөрийнх нь тухай шүүмжлэлтэй материал хэвлэгдсэн сонины бүх дугаарыг... хурааж авсан.”


Сонинууд НӨТ-ийн хөнгөлөлт эдэлдэг боловч энэхүү давуу байдлаа ашиглан орон нутагт борлуулалтаа өсгөхийг төдийлөн идэвхийлдэггүй. Түүнчлэн Улаанбаатарт хэвлэгдэж буй сонинууд орон нутагт болж буй үйл явдлын талаар хангалттай мэдээлж чаддаггүй.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг, нэн ялангуяа хүйн мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэх оролдлого хийхгүй байна. Тухайлбал үндэсний цөөнхөд зориулж казах хэлээр гардаг сонины хэрэгцээ шаардлага өндөр байгаа ч, дэмжлэг дутагдсаны улмаас тогтвортой ажиллаж чадахгүй байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.0


2.4 Төрийн эзэмшлийн хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг улс төрийн зохисгүй нөлөөллөөс хамгаалдаг.

Төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг 1998 онд баталсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хориглосон хэдий ч 12 сонин, 7 телевиз төрийн аль нэг байгууллагын мэдэлд байгаа бөгөөд ихэнхдээ орон нутгийн засаг захиргааны байгууллагаас санхүүжиж байна. Төрийн эзэмшилд буй МОНЦАМЭ агентлагийн даргыг Ерөнхий сайд томилдог бөгөөд уг агентлагаас мөн хэд хэдэн хэвлэл гаргаж байна. МОНЦАМЭ агентлагаас эрхлэн гаргадаг хэвлэлүүд Монголыг гадаадад сурталчилдаг бол төрийн байгууллагаас эрхлэн гаргаж буй бусад мэдээллийн хэрэгсэл бүгд тухайн байгууллагын бодлогыг сурталчлах зорилготойгоор ажилладаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.6

2.5 Өрсөлдөөний тухай хууль болон бусад зохицуулалтаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэт төвлөрөл ба дангаар ноёрхлыг хязгаарладаг.

Хэвлэл мэдээллийн төвлөрөл нь Монголд шинэ үзэгдэл юм. Нэг компани хэд, хэдэн мэдээллийн хэрэгслийг эзэмших үйл явц 90-ээд оны дунд үеэс эхэлсэн боловч сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар төрийн эзэмшлийн МОНЦАМЭ агентлаг 6 сонин, 1 сэтгүүл, “Монгол Ньюс” групп 3 сонин, 1 сэтгүүл (нийтдээ доод тал нь жилд 3,3 сая хувь ширхэгээр хэвлэгддэг), 1 телевиз, “Монгол Масс Медиа” групп 1 өдөр тутмын сонин, 2 телевиз, 3 кабелийн суваг, 1 цахим мэдээллийн хэрэгсэл эзэмшиж буй бол сүүлийн жилүүдэд хүчээ авч буй “Эх Гоёот Медиа” групп 3 сэтгүүл, 1 сонин, 1 телевиз, 1 FM радио, 1 цахим мэдээллийн хэрэгслийг эзэмшиж, сэтгүүлийн зах зээлд ноёрхох байр сууринд шилжиж байна.

Хэвлэл мэдээллийн эзэмшил, харъяаллын асуудал ил тод бус, мөн борлуулалтын мэдээллийг болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувь

хэмжээний талаарх мэдээллийг нууцалдаг учир төвлөрлийн хэмжээг бодитоор тогтоох боломж хомс байна.

Эзэмшлийн ил тод байдлыг ХХЗХ-ны “Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага” хэмээх журмын дагуу зохицуулж, холбогдох мэдээллийг тус Хорооны цахим хуудсанд байршуулсан байдаг. Гэвч аж ахуйн нэгжүүдээс эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа талаар өгч буй мэдээлэл нь эргэлзээтэй тул мэдээллийн хэрэгслийн жинхэнэ эздийг мэдэх боломжгүй байна. Жишээ нь хүнс, хэрэглээний бүтээгдэхүүн, банк санхүү, аялал жуулчлал, уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн зуучлал зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулж буй “Женко” групп нь хэвлэлийн бизнестэй гэж өөрийн цахим хуудсанд мэдэгдсэн боловч хөрөнгө оруулагч ба оруулсан хөрөнгийн хэмжээгээ ил тод мэдээлээгүй байдаг. Хэвлэл мэдээллийн салбарт дангаар ноёрхол үүсэхийг урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн тусгай зохицуулалт байхгүй. Өрсөлдөөний тухай хууль бий боловч хэвлэл мэдээллийн салбарыг

*“Хэвлэл
мэдээллийн
...төвлөрлийн
хэмжээг
бодитоор
тогтоох
боломж хомс
байна.”*

тусгайлан зохицуулсан зүйл үгүй билээ. Эзэмшил харъяаллын тухай мэдээлэл ил тод биш учир олон төрлийн мэдээллийн хэрэгслийг янз бүрийн аргаар ил далд эзэмших бололцоо нээлттэй. Бизнес, улс төрийн том бүлэглэлүүд өөрийгөө тойруулан хэвлэлийн төвлөрөл үүсгэх, нэг нь нөгөөдөө худалдах үйл явц ид өрнөж байна.

2012 оны тавдугаар сард батлагдсан Стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулиар хэвлэл мэдээлэл, уул уурхай, банк санхүүгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт авах үйл явцыг үндэсний аюулгүй байдлын үүднээс зохицуулах заалт орсон. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн асуудалд хяналт тавих анхны алхам юм. Хэвлэлийн байгууллагын нийт хувьцааны таваас дээш хувийг гадаадын иргэн худалдаж авах тохиолдолд Монголын


Засгийн газрын эрх бүхий байгууллагад гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд бүртгүүлэх, нийт хувьцааны 33.33 хувиас дээш хувийг эзэмших тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрлийг нь хэлэлцэх зэрэг зохицуулалтыг шинэ хуулинд тусгажээ.

Мэдээллийн олон ургалч эх сурвалжийг баталгаажуулах хууль эрх зүйн зохицуулалт хийхгүй бол олон ургалч байдлын үндэс суурь хумигдан сулрах аюул байсаар байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.1

2.6 Засгийн газрын зүгээс хэвлэл мэдээллийн салбарын олон талт байдлыг эдийн засгийн хувьд тогтвортой, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих замаар хөгжүүлдэг.

“Ерөнхийдөө сонгуулийн үеэр л шийдвэр гаргагчдын ‘чих зөөлөн’ болж, шаардлагыг хүлээж авдаг.”


Хэвлэл мэдээллийн зарим салбарыг тодорхой хэмжээгээр дэмждэг. Үндэсний олон нийтийн радио, телевизэд жилдээ ойролцоогоор 6 тэрбум төгрөгийн татаасыг Засгийн газар өгч байгаа. Мөн өдөр тутмын сонинуудыг НӨАТ-аас чөлөөлж, орон нутагт телевизийн арваад сувгийг цацах асуудлыг шийдэж төсвөөс хөрөнгө гаргасныг дурьдах нь зүйтэй.

Харин жижиг мэдээллийн хэрэгсэл, ялангуяа орон нутгийн болон хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих ямарваа нэгэн бодлого, санаачлага байдаггүй. Ерөнхийдөө сонгуулийн үеэр л шийдвэр гаргагчдын “чих зөөлөн” болж, шаардлагыг хүлээж авдаг ерөнхий хандлага түгээмэл байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.9

2.7 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн дуу хоолойг үнэн зөв, тэнцвэртэйгээр нийтэд хүргэдэг.

НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн судалгаанаас харахад¹¹ хэвлэлийн эх сурвалжийн дийлэнх нь эрэгтэй хүмүүс байна. Эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийтэд хангалтгүй хүргэдэг бөгөөд энэ нь ялангуяа улс төрийн талбар, тэр тусмаа сонгуулийн үеэр илүү тод харагддаг. Төрийн байгууллагын удирдах түвшний ажилтнуудын дийлэнх нь эрэгтэй байдаг тул эх сурвалжийн хувьд нэвтрүүлэг, ярилцлагад урихад гол төлөв эрэгтэй хүмүүс байдаг аж.


“Эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийтэд хангалтгүй хүргэдэг”

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн асуудалд хэвлэлийнхэн уламжлалт ойлголтоороо, эмэгтэйчүүдийг гэрийн эзэгтэй гэдэг талаас нь хардаг. 2000 ба 2008 оны Парламентийн сонгуулийн үеэр эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн тухай мэдээлэл чанарын хувьд ямар байгаа талаарх харьцуулсан судалгааны¹² дүнд эрэгтэй хүмүүсийг сэтгүүлчид албан тушаал, гүйцэтгэж буй ажлынх нь хувьд бичдэг хэрнээ, эмэгтэй нэр дэвшигчдийг гадаад үзэмж, гэр бүлийн байдал зэргээр нь илүү тодотгож гаргасан жишээ бий.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.3

11 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендерийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт. НҮБ-ын ХАС, Жендерийн тэгш байдлын үндэсний хороо, IRIM 2010 он, 7-р тал

12 Монголын зарим тогтмол хэвлэлд 2000, 2008 онд нийтлэгдсэн эмэгтэй улс төрчдийн талаарх нийтлэлийн харьцуулсан судалгаа. Хэвлэлийн Хүрээлэн, 2012 он

2.8 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн дуу хоолой болж, нийгэм дэх цөөнх, шашин шүтлэг, хэл, улс төрийн төлөөллийн олон талт байдлыг шударгаар илэрхийлж чаддаг.

“Олон нийтийн телевиз... үндэстний цөөнхийн гурван хэлээр... нэвтрүүлэг бэлтгэн цацдаг”


Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийтдээ иргэдийн ялгаатай, олон талт хэрэгцээг хангадаг. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хүрээнд уг байгууллагад олон ургальч байдлыг эрхэмлэх үүргийг тусгайлан оноосон байдаг. Олон нийтийн телевиз энэхүү үүргээ биелүүлж, өөрийн хоёрдугаар сувгаар үндэстний цөөнхийн гурван хэлээр буюу казах, буриад, тува хэлээр нэвтрүүлэг бэлтгэн цацдаг. Гэлээ ч гэсэн “төв халх” аялгыг илүүд үзэж, үндэстний цөөнхийн аялгыг гадуурхах хандлага үе үе гардаг бөгөөд энэ нь социализмын үеэр уламжлагдсан ирсэн ч байж болох юм. Жишээлбэл “дөрвөд хүнийг аялгаас нь болоод нэвтрүүлгээс хассан” тохиолдлыг

хэлэлцүүлэгт оролцогч дурьдаж байв. Казах хэл дээр хоёр сонин гарч байгааг дэвшилтэт хандлага гэж үзэж болно. Харин гадаад иргэдийн тухай, ялангуяа хятадуудын талаар илт гадуурхсан, бүр үзэн ядсан өнгө аясаар мэдээлэх хандлага түгээмэл байна¹³.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.9

¹³ Монголын зарим тогтмол хэвлэлд 2000, 2010 онд нийтлэгдсэн ОХУ, БНХАУ-ын тухай мэдээ, нийтлэлийн харьцуулсан судалгааны тайлан. Хэвлэлийн Хүрээлэн 2011 он


2.9 Засгийн газар мэдээлэл, харилцаа холбоо, технологийн зохистой бодлогоор дамжуулж бүх иргэдийн мэдээллийн хэрэгцээг хангах, эмзэг бүлгийн иргэдийг мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Засгийн газрын төлөөлөгчид мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулж, Интернэтийг хүн бүрт хүртээмжтэй болгох үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүлээн зөвшөөрч байгаа талаараа ярьдаг. Гэхдээ эмзэг бүлгийнхний мэдээлэлтэй байх боломжийг дээшлүүлэх тусгайлан бодлого байдаггүй. Энэхүү хайнга хандлагын улмаас Засгийн газрын нийгмийн халамжийн зарим хөтөлбөр ядуучуудад тэр бүр хүрч чаддаггүй, учир нь эмзэг бүлгийнхэн тэр талаар мэддэггүй, тиймээс эрхээ эдлэхийг нэхэж, шаарддаггүй. Энэ чиглэлээр төрийн бус байгууллагууд сайн ажиллаж, өөрчлөлтийг эхлүүлэх ёстой хэмээн хэлэлцүүлэгт оролцогчид яриу.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.0

2.10 Засгийн газар зар сурталчилгааг зохицуулах эрх мэдлээ редакцийн агуулгад хөндлөнгөөс оролцох хэрэгсэл болгон буруугаар ашигладаггүй.


Төрийн бүх байгууллага хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй бөгөөд мэдээлэл сурталчилгаанд жилдээ ойролцоогоор зургаан тэрбум төгрөг (4.3 сая Ам доллар) зарцуулах төсөвтэй байдаг. Бүх яамд ой, тэмдэглэлт үйл явдал, баяр наадам болохоор реклам сурталчилгаагаа ямар нэгэн тендер шалгаруулалгүйгээр хэвлэлд тавьдаг. Төрийн байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй гэрээ байгуулж ажилладаг бөгөөд уг гэрээнд өөрийн тухай шүүмжлэлт мэдээллийг тухайн мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгээс “хаах” буюу хасах талаар тохиролцдог. Үүний зэрэгцээ эрхлэгч,

редакторуудад засгийн газрын мэдээллийг заавал нийтэлж, нэвтрүүлэх шахалт үзүүлнэ. Бизнесийн байгууллагуудаас сурталчилгаа байршуулах үйл явцад ч мөн ялгаагүй ийм байдлаар нөлөөлөх хандлага гардаг. Хэвлэл мэдээллийнхэн энэ талаар нээлттэй шүүмжилдэг боловч энэ байдалтай эвлэрэхээс өөр аргагүйд хүрдэг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.6

2.11 Монгол улсын сурталчилгааны зах зээл хэвлэл мэдээллийн зах зээлийн олон талт байдлыг дэмжихэд хүрэлцэхүйц хэмжээний том зах зээл мөн.

Монголын рекламны зах зээлд 20 гаруй сая ам. доллар жилдээ эргэлддэг гэсэн Максима консалтинг компанийн судалгаа бий¹⁴. Телевизийн тоон өсөлт нь сурталчилгааны зах зээлийг багасгах биш, харин нэмэгдүүлсэн. Ерөнхийдөө хэвлэл мэдээлэлд реклам нийлүүлж байгаа 4 үндсэн салбар байна. Үүнд, үүрэн холбооны операторууд, банкууд, олон улсын төсөл хөтөлбөрүүд болон уул уурхайн компаниуд ордог. Сурталчилгааны зорилтот хэрэглэгчдийн дийлэнх нь Улаанбаатар хотод амьдарч байгаа учир хөдөө орон нутагт сурталчилгааны зах зээл маш бага байна. Үүний улмаас орон нутагт мэдээллийн хэрэгсэл шинээр байгуулах, тогтвортой хөгжүүлэх боломж хомс байна.

“Сурталчилгааны зорилтот хэрэглэгчдийн дийлэнх нь Улаанбаатар хотод амьдарч байгаа.”

Сүүлийн 3 жилд далд сурталчилгаа өсөн нэмэгдэж буйг тэмдэглэх хэрэгтэй. Сэтгүүлзүйн хэлбэрээр бэлтгэсэн, үзэгч, уншигчдад сурталчилгаа гэж танигдахааргүй шууд бус сурталчилгаа нь сүүлийн жилүүдэд ердийн сурталчилгаанаас ч илүү их болж байна. Энэ нь сурталчилгааны зах зээлийн талаар бодитой үнэлгээ хийх боломжийг улам

14 Максима Консалтинг: Дэлхийн медиа зах зээл тогтмол өсөж байна. Монголын ТВ-ийн реклам зар сурталчилгааны зах зээлийн олон улсын медиа зах зээлтэй харьцуулсан презентаци. <http://www.docstoc.com/docs/50632293/MAXIMA-Media-market>, 2012 оны 12 дугаар сарын 11.


бүр хумиж байгаа юм. Ийм үнэлгээний дүнд ямар ч тоо баримт гарлаа гэсэн, одоогоор үйл ажиллагаа явуулж буй 218 хэвлэмэл, 221 өргөн нэвтрүүлгийн байгууллагыг энэ зах зээл сурталчилгаагаар тэтгэж чадахгүй нь тодорхой.

Онолын хувьд маркетингийн ажилтнууд өөрийн бүтээгдэхүүнийг сонирхох хамгийн олон хэрэглэгчтэй мэдээллийн хэрэгсэлд сурталчилгаагаа байршуулах ёстой. Гэтэл Монголд бүх төрлийн бүх мэдээллийн хэрэгсэлд ялгаваргүйгээр сурталчилгаа байршуулах явдал нэлээд түгээмэл байдаг. Үүний уршгаар сурталчилгааны үнэ ханш унаж, улмаар олон ургальч хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэхүйц хэмжээний орлого бүрдэх боломж хомсдож байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.1

2 БҮЛГИЙН ДУНДАЖ ОНОО

3.0

ГУРАВДУГААР БҮЛЭГ:

**Өргөн нэвтрүүлгийг ил тод, хараат
бус байдлаар зохицуулдаг. Төрийн
мэдлийн радио телевизийг жинхэнэ
утгаар нь олон нийтийн радио телевиз
болгон өөрчилж чадсан.**

Гуравдугаар бүлэг: Өргөн нэвтрүүлгийг ил тод, хараат бус байдлаар зохицуулдаг. Төрийн мэдлийн радио телевизийг жинхэнэ утгаар нь олон нийтийн радио телевиз болгон өөрчилж чадсан.


3.1 Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдан гарсан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлснээр олон нийтийн, арилжааны болон хүйн/иргэдийн радио телевизийн тус бүрийн орон зайг бий болгож чадсан.

Өргөн нэвтрүүлгийн салбарыг ерөнхийдөө Монгол Улсын Харилцаа холбооны тухай болон Радио долгионы тухай хуулиар зохицуулдаг. Харилцаа холбооны тухай хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулна. Энэхүү Хорооноос гаргасан журмуудаар арилжааны өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг зохицуулдаг бөгөөд 2005 онд батлагдсан Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг зохицуулдаг. Хүйн радио телевизийг зохицуулах эрх зүйн баримт бичиг байдаггүй учир ийм байгууллагад тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн үндэс суурь үгүйлэгдэж байна. Одоо үйлчилж буй хуулийн хүрээнд хүйн мэдээллийн хэрэгсэл үүсгэн байгуулахын тулд төрийн бус байгууллага байгуулж бүртгүүлэх ёстой. Харилцаа холбооны зохицуулах хорооныхон энэ мэтээр журмынхаа хүрээнд нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй өргөн нэвтрүүлгийн байгууллагуудыг зохицуулж байгаа бол, хөдөөгийн өргөн нэвтрүүлгийг огт хянаж чадахгүй байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.0

3.2 Өргөн нэвтрүүлгийн асуудлыг хараат бус байгууллага зохицуулдаг. Уг байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх нөхцөлийг хуулиар бүрдүүлсэн. Тус байгууллагын Удирдах зөвлөлийг ил тодоор иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан бүрдүүлдэг бөгөөд уг Зөвлөлд аль нэг улс төрийн намын төлөөлөл давамгайлдаггүй.

Харилцаа холбооны тухай уулийн 8.6.1-д Харилцаа холбооны зохицуулах хороо нь “эдийн засаг, мэдээлэл холбоо, техник, хууль зүй, удирдлагын дээд боловсролтой” зургаан орон тооны бус гишүүнээс бүрдэх бөгөөд дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилно (8.3-р зүйл) гэж заасан байдаг. Энэ байгууллагын удирдлагыг томилох үйл явцад иргэний нийгмийн оролцоо байдаггүй.


Уг байгууллагын санхүүжилтийн хувьд үүрэн холбооны операторуудын хураамжаар санхүүгийн гол эх үүсвэрээ бүрдүүлдэг.

“ХХЗХ-ны удирдлагын томилгоонд иргэний нийгмийн оролцоо байдаггүй.”

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.6

3.3 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, лицензийг зохицуулагч байгууллага зохицуулалтыг шударгаар, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн гүйцэтгэж, ерөнхийд нь нийгмийг төлөөлж чадахуйц үзэл бодлын олон талт байдлыг хангаж чаддаг.

Өргөн нэвтрүүлгийн лицензийг дуудлага худалдаа болон тендерийн аргаар олгодог. Нэг удаа дуудлага худалдаа зохион байгуулахад “Монгол ТВ” 806 сая төгрөгөөр лиценз авсан. Харилцаа холбооны зохицуулах газраас дахиж ийм дуудлага худалдаа зарлах нь эрсдэлтэй гэж үзсэн. Учир нь их мөнгө гаргасан этгээдэд лиценз олгоод, ард нь хэн байгааг мэдэхгүй үлддэг аж.

*“Эрх барьж буй
намаас тусгай
зөвшөөрөл
олголтонд
хүчтэй
нөлөөлдөг.””*

Радио долгионы тухай хуулийн 10.1.4-т заасны дагуу радио долгионы тусгай зөвшөөрөл авах өргөдөл бүрдүүлж буй иргэн “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт” авсан байх шаардлагатай.


Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлагын бүтцийн улмаас эрх барьж буй намаас тусгай зөвшөөрөл олгох үйл явцад их нөлөөлдөг. Жишээлбэл МАХН эрх барьж байсан үед энэ намд талтай сувгууд байгуулагдсан

бол дараагийн дөрвөн жилд нь буюу 2004- 2008 оны эвслийн засгийн газрын үед голчлон Ардчилсан намын байр суурийг дэмждэг зүтгэлтнүүд тусгай зөвшөөрөл авч, сувгаа нээсэн байдаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.7

3.4 Олон нийтийн радио телевиз нь нийгмийг бүхэлд нь төлөөлж чадах, хараат бус, нээлттэй, ил тод арга замаар сонгогдсон Үндэсний зөвлөлөөрөө дамжуулан олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг.

2005 оны Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.4-т заасны дагуу тус байгууллагын Үндэсний зөвлөлийн гишүүдийг иргэний нийгмийн санал болгосон хүмүүсээс томилох ёстой. Гэхдээ эцсийн шийдвэрийг УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газрын саналд үндэслэн гаргадаг. Анхны Үндэсний зөвлөлийн 15 гишүүнийг сонгох сонгуулийг төрийн бус байгууллагууд маш сайн зохион байгуулсан. Энэ үеэр төрийн бус байгууллагууд хэд хэд удаа зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Үндэсний зөвлөлд нэр дэвшүүлэх журмаа тохиролцоод, тохирсон журмынхаа дагуу салбар тус бүрээс хүнээ дэвшүүлсэн бөгөөд УИХ –аас тэдгээрийн 60 хувийг хүлээн зөвшөөрч албан ёсоор томилсон. Үүнээс хойш томилгоо улс төрийн шийдлээр явагддаг болсон. 2012 оны 9 дүгээр сард Үндэсний зөвлөлийн 7 гишүүний томилгоог хийхэд ч иргэний нийгмийн ямар нэг уулзалт, зөвлөлгөөн болоогүй бөгөөд Үндэсний зөвлөлийн бүх гишүүн улс төрийн ямар нэгэн хамааралтай, томилгоо нь өөрөө цэвэр улс төрийн шийдвэр болдог гэх хардлага түгээмэл байна.


“Үндэсний зөвлөлийн бүх гишүүн улс төрийн ямар нэгэн хамааралтай, томилгооны үйл явц нь өөрөө цэвэр улс төрийн шийдвэр болдог гэх хардлага түгээмэл байна.”

Үндэсний Зөвлөлийн гишүүд хэний ч өмнө хариуцлага хүлээхгүй байна. Олон нийтийн өмнө тайлангаа тавих байдлаар хариуцлага хүлээх нь ёс төдий хэрэгждэг. Үндэсний Зөвлөлийн гишүүдтэй хариуцлагын асуудал ярьж, эгүүлэн татах эрх бүхий этгээд нь хуулийн дагуу Хяналтын зөвлөл боловч энэхүү Зөвлөлд Үндэсний Зөвлөлийн гишүүд багтдаг гол асуудал оршиж байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.0

3.5 Төрийн ба улс төрийн намуудын албан тушаалтнууд болон радио телевизийн үйл ажиллагаа явуулж буй ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс төрийн/ олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлд гишүүнээр томилогдох боломжгүй.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.3-т Үндэсний зөвлөлийн гишүүнд төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, бусад радио телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход оролцдог этгээд, бусад радио телевизэд хөрөнгө оруулсан этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээдийг нэр дэвшүүлэхгүй” хэмээн заасан байдаг.


*“Бодит байдалд
Үндэсний зөвлөлийн
гишүүнд сонирхлын
зөрчилтэй...
хүмүүсийг төрийн
бус байгууллагын
халхавчаар
томилдог.”*

Бодит байдалд Үндэсний зөвлөлийн гишүүнд сонирхлын зөрчилтэй, дээрх хуулийн дагуу томилж болохгүй хүмүүсийг төрийн бус байгууллагын халхавчин дор томилдог. Жишээлбэл Улс төрийн боловсролын академийн нэрээр Үндэсний зөвлөлд орж ирсэн гишүүн нь Ардчилсан Намын олны танил төлөөлөл болохыг олон хүн мэдэж буй. Үндэсний зөвлөлийн өөр нэгэн гишүүн тухайн үедээ арилжааны телевизийн зөвлөхөөр ажиллаж, өөрөөр хэлбэл ашиг сонирхлын зөрчилтэй байсан зэрэг дутагдал гардаг байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.8


3.6 Олон нийтийн радио телевизийн редакцийн хараат бус байдлыг улс төрийн нөлөөллөөс хуулиар хамгаалсан бөгөөд бодит амьдралд уг хараат бус байдал нь хэрэгждэг.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Олон нийтийн радио телевизийн сурвалжлагч, редакци үндсэн хууль болон энэхүү хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” хэмээн заасан байдаг. Харин бодит амьдрал дээр тус байгууллагын удирдах бүтцийг хараат бусаар томилж чаддаггүй тул энэхүү заалт хэрэгждэггүй.(3.4 дүгээр шалгуур үзүүлэлтийг харна уу)

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.6

3.7 Олон нийтийн радио телевизийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлж, төсвөөр болон бизнесийн дарамтаар дамжуулж хөндлөнгөөс нөлөөлөх явдлыг хязгаарладаг.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар тус байгууллагыг нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс, зар сурталчилгаанаас олсон орлого, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хандив, тусламж, улсын төсвийн дэмжлэг болон хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Олон нийтийн телевизийн өрхийн хураамж сард 1100 төгрөг (0,80 Ам доллар) байдаг бөгөөд үүнийг цахилгааны төлбөртэй хамт банкаар дамжуулан авдаг. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооныхон энэхүү орлогыг найдвартай хэмээн үзэж буйгаа дараах тооцоонд үндэслэж байсан: Монголын нийт өрхөөс дор хаяж Улаанбаатар хотын 300 гаруй мянган өрх хураамжаа төлбөл 4 тэрбум төгрөг (2,8 сая Ам доллар) болно. Харин

Олон нийтийн радио телевизийн удирдлагын үзэж буйгаар өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай Монгол шиг улс оронд хураамжаас хангалттай хэмжээний орлого бүрддэггүй, зар сурталчилгааны орлого хязгаарлагдмал (эфирийн цагийн 2 хувь хүртэлх хэмжээний арилжааны бус сурталчилгаа) учир төсвөөс хэт хамааралтай байдалд орж, энэ нь эргээд улс төрийн буюу төсөв шийдэж буй албан тушаалтнуудын нөлөөнд орох үүд хаалгыг нээж буй аж.

Дээр дурьдсан бүх төрлийн санхүүжилт Сангийн ямаар дамжиж Олон нийтийн радио телевизийн дансанд ордог учир төрийн санхүүжилтэд хамаарах дүрэм журам, тухайлбал ажилтнуудын цалингийн сүлжээ зэрэг нь уг байгууллагад адилхан үйлчилдэг.


Олон нийтийн телевиз орлогын хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд төлбөртэй нэвтрүүлэг, ивээн тэтгэлэг зэргийг шохоорхсоор байна. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13.2.2-т “улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх” тухай заасан байдаг хэдий ч тус телевиз мэдээллийн хөтөлбөрийн цагийнхаа нэг хувийг сурталчилгаанд зориулж байна. Мөн зарим сэтгүүлч хөдөө орон нутагт томилолтоор ажиллахдаа зардлаа нөхөх үүднээс ивээн тэтгэлэг, төлбөрт мэдээлэл бэлтгэж ирэхийг хичээдэг бөгөөд энэ бүгд нь тус телевизийн хараат бус тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.

“Зарим сэтгүүлч хөдөө орон нутагт томилолтоор ажиллахдаа... ивээн тэтгэгч олж төлбөрт мэдээлэл бэлтгэж ирэхийг хичээдэг.”

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.9


3.8 өрийн/олон нийтийн радио телевизийн нэвтрүүлгийг улс орон даяар хүлээн авах боломжтой.

Монголын Олон Нийтийн Радио, Телевизийг үндэсний хэмжээнд хүлээн авах боломжтой.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

5.0

3.9 Олон нийтийн радио телевиз нь хөтөлбөрийн олон талт байдлыг хангаж, бүхий л төрлийн сонирхолд нийцэх нэвтрүүлгийн олон хэлбэрийг ашигладаг.


“Олон нийтийн телевизийн хөтөлбөр нь... олон ургальч байж чаддаг.”

Олон нийтийн телевизийн хөтөлбөр нь арилжааны бусад телевизтэй харьцуулахад илүү олон ургальч байж чаддаг бөгөөд чанарын хувьд тодорхой хэмжээгээр ахиж байгаа. Тус телевиз эдийн засаг, улс төр, гэр бүлийн зэрэг олон асуудлаар, мөн хүүхэд залуучууд, танин мэдэхүйн болон цэнгээнт нэвтрүүлгийг бэлтгэж цацдаг бол хоёрдугаар сувгаараа үндэстний цөөнхөд зориулж, тэдний хэлээр нэвтрүүлэг явуулдаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.4

3.10 Олон нийтийн радио телевиз олон талт үзэл бодол, байр суурийг бүрэн багтаасан тэнцвэртэй, цаг үеийн мэдээ, мэдээллийг түгээдэг.

2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсанаас хойш Үндэсний Олон Нийтийн Телевизийн мэдээллийн хөтөлбөр ихэд сайжирсан боловч сүүлийн жилүүдэд энэхүү эерэг өөрчлөлт нь сөрөг тийшээ эргэж байна.

Өнөөдрийн байдлаар тус телевизийн мэдээллийн хөтөлбөрийн агуулга нь арилжааны бусад телевизтэй харьцуулахад хамгийн “мөлгөр” буюу уйтгартай, нэг янзынх


“Зөрчилтэй асуудлыг тойрч өнгөрөх хандлагатай бөгөөд шүүмжлэлт, дүн шинжилгээ хийсэн бүтээл хомс гардаг.”

байдаг. Ихэнхдээ төрийн үйл ажиллагаа, тэр дундаа Засгийн газрын хэдэн гишүүнийг тойрсон мэдээлэл, сурталчилгаанд гол анхаарлаа хандуулж буй мэт сэтгэгдэл төрүүлдэг. Хэвлэлийн Хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “МҮОНТ-ийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг” судалгааны дүнгээр МҮОНТ-ийн мэдээллийн хөтөлбөрөөр цацсан нийт мэдээний 30 хувийг дан ганц эх сурвалжид тулгуурлан бэлтгэсэн, тэдгээрийн дийлэнх нь төрийн өндөр албан тушаалтан, сайд, дарга нар байна¹⁵. Зөрчилтэй асуудлыг тойрч өнгөрөх хандлагатай бөгөөд шүүмжлэлт, дүн шинжилгээн дээр суурилсан бүтээл хомс гардаг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.8

3.11 Олон нийтийн радио телевиз олон талт, бүтээлч өөрийн бэлтгэсэн агуулгыг санхүүгийн боломжийнхоо хэрээр түгээдэг.

МҮОНТ өөрийн хүч, хөрөнгөөр өөрсдөө бэлтгэсэн нэвтрүүлгийн эзлэх хувиараа бусад телевизээс өндөр үзүүлэлттэй байдаг. Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгаагаар эфирийн нийт цагийн 60 хувьд нь¹⁶ өөрийн бүтээлийг цацаж байна. Мөн олон улсын байгууллагуудын санхүүжилт бүхий, төслийн хүрээнд бэлтгэсэн нэвтрүүлгүүд харьцангуй өндөр хувьтай байдаг. Ерөнхийдөө өөрийн бэлтгэсэн агуулгыг боломжийн хэрээр цацаж байгаа боловч бүтээлч байх тал дээр дутагдалтай хэмээн хэлэлцүүлэгт оролцогчид дүгнэлээ. Олон нийтийн телевизийн долоо хоногийн хөтөлбөрт цөөн нэвтрүүлгийн төрөл зонхилох байр суурийг эзэлдэг (тухайлбал мэдээллийн хөтөлбөр, нэг асуудлыг хэсэг бүлэг хүнээр хэлэлцүүлэх ярилцлагын нэвтрүүлэг, баримтат нэвтрүүлэг болон уран сайхны кино) бөгөөд харин мэдээллийн шинжтэй болон цэнгээнт шоу, хөгжимт нэвтрүүлгийн олон хэлбэрийг тэр бүр ашиглахгүй байна.¹⁷

15 “МҮОНТ-ийн Шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг”, Хэвлэлийн Хүрээлэн, 2011 он, 11-р тал


16 Мөн тэнд, 14-р тал

17 МҮОНТ-ийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг 3. Хэвлэлийн Хүрээлэн 2011 он, 21-22-р тал.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.7

3.12 Хүйн радио телевизийг үзэх, сонсох боломжийг нэмэгдүүлэхийг Засгийн газраас онцгойлон дэмждэг.


Тодорхой сонирхлоор нэгдсэн, тухайлбал газар зүйн хувьд, эсхүл байгууллага, хамтын сонирхлоор нэгдсэн хүмүүс өөрсдийн мэдээллийн хэрэгслийг ашгийн бус зорилгоор ажиллуулахыг хүйн буюу иргэдийн мэдээллийн хэрэгсэл гэж ойлгож болно. Ийм төрлийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин Монголд байхгүй хэдий ч тэдгээр нь тодорхой хэмжээгээр оршин тогтнож байна. Жишээ нь Хэнтий аймаг дахь Дөлгөөн Хэрлэн ОНП-г авч үзвэл ашгийн бус, нутгийн иргэдийнх мэт боловч гэр бүлийн бизнес тал руу хэвийсэн, эсвэл хувь хүний бизнес болсон байдаг. ЮНЕСКО-гийн болон Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн дэмжлэгээр ийм төрлийн хэд хэдэн радио байгуулсан ч үйл ажиллагаа бие даан явуулж чадалгүй зогссон. Саяхан Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Итгэлцлийн Trust Fund сангийн төслийн хүрээнд ЮНЕСКО-гийн тусламжаар баруун дөрвөн аймгийн алслагдсан арван суманд хүйн радио байгуулаад байна. Өмнө нь зөвхөн тоног төхөөрөмж өгдөг байсан бол одоо орлого олж, тогтвортой ажиллах аргыг давхар зааж өгч байгаа аж.

Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрийн зүгээс дэмжих шаардлагатай гэсэн зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд Засгийн газарт өгсөн. Одоогоор энэ төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монгол оронд маш цөөн, голдуу олон улсын байгууллагын тусламжтайгаар ажиллаж байгаа бөгөөд төрөөс ямарваа нэгэн бодлого, дэмжлэг байхгүй тул олон улсын төслийн хөрөнгө дуусмагц зогсох хандлагатай байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.4

3 БҮЛГИЙН ДУНДАЖ ОНОО:

2.6

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
мэргэжлийн хэм хэмжээг хангахуйц
өндөр түвшинд ажилладаг.

Дөрөвдүгээр бүлэг: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэргэжлийн хэм хэмжээг хангахуйц өндөр түвшинд ажилладаг.

4.1 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэргэжлийн ёс зүйг сайн дурын үндсэн дээр мөрддөг бөгөөд эдгээрийн хэрэгжилтийг олон нийтийн санал гомдлыг хүлээн авах өөрийн зохицуулалтын байгууллагууд хангаж байдаг.

Ардчилал, зах зээлд шилжсэнээс хойш хэвлэл мэдээллийн салбарын эвсэл, холбоод өөр өөрсдийн ёс зүйн дүрмийг тунхаглаж ирсэн. 2005 онд Монголын Сэтгүүлчдийн Холбоо, Монголын Ардчилсан Сэтгүүлчдийн Холбоо хэмээх хоёр байгууллага нэгдэж, ёс зүйн дүрмээ баталж, 2011 онд шинэчилсэн боловч хэрэгждэггүй хэвээр л байна. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн ёс зүйн дүрэмтэй. Жишээлбэл МОНЦАМЭ-д өөрийн Алтан дүрэм гэж байдаг. Мөн Ардын эрх сонин өөрийн ёс зүйн кодтой. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй учир цаасан дээр л үлддэг. Олон Нийтийн Радио Телевиз өөрийн ёс зүйн дүрэмтэй бөгөөд иргэдийн санал гомдлыг хүлээж авах тухай хуулийн заалт ч байдаг.

“Зөвхөн дээд албан тушаалтнаас уучлалт гуйх нь элбэг.”

Зарим сонинд уучлалт гуйх нь түгээмэл болж байна. Алдаа гаргах бүрт уучлалт гуйгаад байдаггүй хэдий ч, ийм аргаар өөрийгөө хамгаалах гэж оролдох нь элбэгшиж байна. Тухайлбал хэн нэгэн сэтгүүлч баримтат мэдээлэл нийтэлж, түүнийх нь ул мөрөөр аль нэгэн улс төрч гомдол гаргахад эрхлэгч нь тухайн баримтыг нягтлан шалгах ч үгүйгээр уучлал гуйх аргаар асуудлыг бушуухан шийдэхийг хичээнэ. Ингэхдээ зөвхөн дээд албан тушаалтнаас уучлалт гуйх нь элбэг бөгөөд энгийн иргэдийн эрхэд халдсан тохиолдолд хариуцлага хүлээх хэм хэмжээ байдаггүй.

Ёс зүйн консул байгуулах асуудал маш олон жил яригдсан. 2007 онд Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр Хэвлэлийн эрх чөлөөний олон улсын өдрөөр хэвлэлийн консул байгуулах санаачлага гаргаж, дэмжих сонирхлоо илэрхийлж байв. Харин тухайн үеийн Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч нэг жилийн төсвийг нь улсаас гаргаж өгөөч хэмээн хүсэлт гаргаж, Ерөнхийлөгч ч зөвшөөрсөн. Гэтэл хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлага үүнийг эсэргүүцэж, бизнесийн боломжийг нь хязгаарлах зохицуулалт хийдэг,

“Мөнгөтэй хүмүүс мэргэжлийн хэм хэмжээг мөрдөх дургүй.”

хэвлэлийн эздийн эсрэг байгууллага бий болохвийг гэдэгт болгоомжилж буйгаа илэрхийлсэн. Үүнээс хойш өөрийн зохицуулалт бий болгох гэсэн тохиолдол бүр эздийн эсэргүүцэлтэй тулгарч гарч байв. “Мөнгөтэй хүмүүс мэргэжлийн хэм хэмжээг мөрдөх дургүй” хэмээн хэлэлцүүлэгт оролцсон нэгэн дурьдсан. Сэтгүүлчид ч ёс зүйн консул байгуулах санал санаачлагад болгоомжтой хандаж буй бөгөөд тэд хяналтын нэг шинэ зэвсэг, эсхүл Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөл шиг байгууллага бий болох вий хэмээн айж байна.


“ямар нэгэн үйлдэл хийх нь чухал, эс тэгвээс сэтгүүлзүйн чанарын тухай яриа улам бүр газар авах болно”

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Консул байгуулахыг хуульчлахаар тусгасан. Хуульчлах нь мэргэжлийн хэм хэмжээг дээшлүүлэх тийм ч сайн арга биш гэдгийг хэлэлцүүлэгт оролцогчдын зарим нь онцолж байсан. Үүний оронд хэвлэл мэдээллийнхэн санаачлагыг өөрсдийн гарт авах хэрэгтэй гэх хүн байв. Аль ч тохиолдолд “ямар нэгэн үйлдэл хийх нь чухал, эс тэгвээс сэтгүүлзүйн чанарын тухай яриа улам бүр газар авах болно” гэдэгтэй хэлэлцүүлэгт оролцогчид санал нийлэв.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.3

4.2 Сэтгүүлзүйн үйл ажиллагаа нь нягт нямбай, шударга байх үндсэн зарчимд захирагддаг.

Хэвлэл мэдээллийнхэний дунд нягт нямбай байх тал дээр асуудал бий. Нэр солих, үг үсгийн алдаа маш түгээмэл. Нэгэн оролцогч “Сонинд ярилцлага өгөхдөө “Ёс зүйг хуулиар зохицуулах ёсгүй” гэж хэлснийг маань эсрэгээр нь “хуулиар зохицуулах ёстой” гээд биччихсэн байсан. Дараа нь би маш эвгүй байдалд орсон” гэв. Телевизийн нэвтрүүлэгчид царай зүс сайтай байдаг хэдий ч сэтгүүлзүйн тухай ямар ч ойлголтгүй байх нь маш түгээмэл. Ер нь тухайн редакцийн тал хувь нь л сэтгүүлзүйн мэдлэг, боловсролтой байдаг бол үлдсэн

хэсэг нэтэс өөр ажил хийж байгаад хэвлэл мэдээллийн салбарт орж ирсэн хүмүүс байдаг.

“Сонинд ярилцлага өгөхдөө “Ёс зүйг хуулиар зохицуулах ёсгүй” гэж хэлснийг маань эсрэгээр нь... биччихсэн байсан.”

Сэтгүүлзүйн мэргэжлийн түвшин дорой байгаагийн нэг шалтгаан нь сэтгүүлчид цагийн дарамтанд, маш шуурхай ажилладагаас үүдэлтэй. Түүнчлэн редакцийн өдөр тутмын ажилд хяналтын шат дамжлага байхгүй болсонтой холбоотойгоор ч алдаа мадаг их гарч байна. Нөгөө талаас маркетинг ба сэтгүүлчид тусдаа ажиллах зарчим Монголд бодит утгаараа хэрэгжихгүй байна. Сурталчилгааны хэлтсээс сэтгүүлчдэд үүрэг даалгавар өгдөг. Сэтгүүлчид өөрсдөө төлбөртэй мэдээлэл олж ирвэл хувь хүртдэг. Нэр хүндтэй, олон жилийн туршлагатай сэтгүүлчид ч ялгаагүй,


цалингийнхаа санхүүжилтийг баталгаажуулахын тулд төлбөрт мэдээлэл олох ажилд оролцдог. Энэхүү тойргоос хэн ч татгалзаж чаддаггүй бөгөөд ихэнх нь “Мөнгө нь хэрэгтэй учир үгүй гэж хэлж чаддаггүй” гэнэ. Гэхдээ мэргэжлийн үүднээс нь авч үзвэл ийм зүйлийг хүлээн зөвшөөрч хэрхэвч болохгүй гэдэгтэй хэлэлцүүлэгт оролцогчид санал нийлж байв. Тиймээс төлбөртэй сэтгүүлзүйг төгсгөл болгохын төлөө сэтгүүлчид өөрсдөө хүчээ нэгтгэх хэрэгтэй гэж тэд үзсэн.

“Мөнгө нь хэрэгтэй учир үгүй гэж хэлж чаддаггүй.”

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.1

4.3 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл эдийн засаг, соёл, орон нутгийн болон эрэн сурвалжилсан мэдээллийг багтааж, үйл явдал, сэдвийн өргөн хүрээг хамардаг.

Монголд хэдэн зуун мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байгаа учир тэд бүхэлдээ олон төрлийн мэдээллийг түгээдэг.

Иргэд үнэн бодит мэдээллээр цангаж буй боловч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл үнэмшил нь нэлээд буурсны улмаас мэдээлэл болгоныг “үүний ард хэн байна вэ?” гэх хардлагаар хүлээж авч байна. Зарим даацтай бүтээлийг хэн нэгэн зориудаар төлбөрийг нь төлж, эсвэл сонирхлын зөрчил бүхий аль нэгэн талын мэдээлэлд үндэслэн гаргадаг учир ийм төрлийн мэдээлэлд ч үл итгэх байдлаар хандах нь түгээмэл.

“Зарим даацтай бүтээлийг хэн нэгэн зориудаар төлбөрийг нь төлж... гаргадаг учир... үл итгэх байдлаар хандах нь түгээмэл.”


Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл хоцрогдож, хөдөөгийн иргэдэд мэдээллийн сонголт бага байна. Өдөр тутмын сонинууд нийслэл хотоос гадуурх мэдээлэлд бага анхаарч, Үндэсний Олон Нийтийн Телевиз хөдөө нутгийн асуудалд харьцангуй бага цаг зарцуулж байна. Харин хувийн ТВ9 телевиз аймаг бүрт сурвалжлагч ажиллуулж байгаа нь авууштай.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өөрийн гэсэн хүндрэл бэрхшээл тулгарч байна. Тэд эдийн засгийн маш хүнд нөхцөлд ажиллаж буй учир аймгийн захиргаа болон аж ахуйн нэгж, компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулах замаар сурталчилгааны орлогоо нэмэгдүүлэхийн төлөө өөр хоорондоо хүчтэй өрсөлддөг.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

3.6

4.4. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилтнууддаа нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, нийгмийн бүлэг, хүйс, үзэл бодол, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, наснаас үл хамааран тэгш боломжийг олгодог.

“Үзэл санааны эсэргүүцэл илэрхийлсэн сэтгүүлчид бэрхшээлтэй тулгардаг.”

Уламжлал ёсоороо Монголд ялгаварлан гадуурхах заншил байдаггүй, хуулийн хүрээнд ч бүх хүний эрх тэгш байдлыг баталгаажуулсан байдаг.


Хэвлэл мэдээллийн салбарт эмэгтэйчүүд тооны хувьд арай илүү боловч хүйсийн тэнцвэр төдийлөн алдагдаагүй байна. Энд ажилтнуудыг гарал үүсэл, хүйс, шашин шүтлэг зэргээр нь ялгаварлах ёс байдаггүй. Насны хувьд залуучууд давамгайлдаг бөгөөд өндөр настай хүн харьцангуй ховор. Нас өндөрсөх тусам тэд залуучуудаас дайжиж, арай илүү эрх мэдэл бүхий ажилд татагддаг бололтой. Үзэл санааны эсэргүүцэл илэрхийлсэн сэтгүүлчид бэрхшээлтэй тулгардаг. Тэд ерөнхийдөө аль хэвлэл мэдээллийн байгууллага улс төрийн ямар чиг шугам барьдагийг мэдэх учир ажилд орохдоо

сонголтоо зөв хийхийг хичээнэ. Тухайн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг хүлээн зөвшөөрөхгүй бол ажлаас халагдах магадлал өндөр. Өөр ажилд орох нь зарим талаар бэрхшээлтэй, учир нь эрхлэгчид хоорондоо ярилцаж, тодорхой хүмүүсийг ажилд авахгүй байх талаар тохиролцох нь бий.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

4.6

4.5 Сэтгүүлчид болон редакторууд үйл ажиллагаандаа өөрийн цензур тавьдаггүй.

Өөрийн цензур Монголд маш түгээмэл. Энэ тал дээр хэд хэдэн бичигдээгүй хууль бий: Хөрөнгө оруулагч ба хөрөнгө оруулагчдын найз нөхдийн талаар муу юм бичиж болохгүй. Эрх мэдэл бүхий зарим хүнээс болгоомжлох хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч редакцийн бодлогыг тодорхойлох бөгөөд түүний бодлогыг ажилтан биелүүлэх үүрэгтэй. Сэтгүүлч, редакторуудад учрах эдгээр бэрхшээл дээр цөөн хүн амтай жижиг улсын зовлон нэмэгдэнэ. Таних мэдэх хүн олон учир нүүр халуун, дээрээс нь бусдыг дайрч гомдоохгүй байх ерөнхий хандлага нь байдлыг улам хэцүү болгоно. “Буруу” хүнийг шүүмжилж, “буруу зүйл” бичсэн хүнээс нүүр буруулах нь амархан.

“Цөөн хүн амтай жижиг улсын хувьд ... бусдыг дайрч гомдоохгүй байх ерөнхий хандлага нь байдлыг улам хэцүү болгоно.”


Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлийн дагуу гүтгэхийг гэмт хэрэгт тооцдог учир энэ нь өөрийн цензурт ташуур өгдөг.

Социалзмын үед нийгмийн тогтолцоог ерөнхийд нь шүүмжилж болдоггүй байсан хэдий ч жижиг даргыг бол хатуу шүүмжилдэг байв. Одоо бол эсрэгээр, маш ерөнхий шүүмжилдэг болсон. Жишээлбэл зам дээрх нүхний талаар бичвэл харилцагч байгууллагатай зөрчилд орж болзошгүй учраас Монголын автозамын салбарын алдаа дутагдал, дэд бүтцийн талаар ерөнхийд нь шүүмжилнэ.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.3

4.6 Нийгэмд байр сууриа олсон, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд редакцийн хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлдөггүй.

“Иийдвэр гаргах эрхийг эрхлэгчдэд олгох тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллага ашиггүй ажиллаж эхэлнэ гэдэгт эзэмшигчид итгэдэг.”

1990 оноос хойш цензурыг төрөөс биш, хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигчийн зүгээс тавьдаг болсон. Эзэмшигчид тэр бүр редакци дээр ирж зааварчилгаа өгөөд байхгүй, харин эрхлэгч, редакторуудад итгэл, хариуцлагыг хүлээлгэх бөгөөд тэд байнга ёвруулаад байлгүйгээр хэнийг дагахаа мэднэ гэж үздэг. Глоб интернэшнлээс арав орчим редакцийн дунд судалгаа явуулж үзэхэд, сэтгүүлчдийн 60 хувь нь редакцийн цензур байна гэж хариулжээ.¹⁸


Сэтгүүлчид өөрсдийнхөө төлөө тэмцэж ирсэн уламжлал Монголд үгүйлэгдэж байна. Гэтэл эздийн хэт оролцоог багасгахын тулд сэтгүүлчийн өөрийн оролцоо чухал. Зарим

сэтгүүлч эздийн дарамт шахалтаар биш, мэргэжлийн хэм хэмжээнд захирагдан ажиллах өөрийн гэсэн мэдээллийн хэрэгсэлтэй болох боломжийг эрэлхийлж байна.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.0

18 М.Батсуурь, Редакцийн хараат бус байдал: Эрх зүйн зохицуулалт ба харьцуулалт. Глоб Интернэшнл 2010 он. <http://globeinter.org.mn/?cmd=Record&id=785&menuid=364>

4.7 Сэтгүүлчид ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл шударгаар ажилладаг бөгөөд хээл хахуульд автдаггүй.


Өнөөгийн нийгэмд сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэн бусдын адил мөнгийг дагадаг болсон нь харамсалтай. Энэ талаар олон жишээ дурьдаж болно. Зарим редактор зардлаа нөхөх нэрийдлээр авилгал нэхдэг. Сэтгүүлчид үдийн хоол, оройн зоог, үнэ төлбөргүй амралт, зугаалга, байр, машин, албан тушаал, эсвэл Хятад, Солонгосоор аялах боломжийг алддаггүй. Харьцуулбал, 2000 оны үед авилга ил тод байсан. Одоо арай хумигдсан тал бий. Илүү далд хэлбэртэй болсон байж ч болох.

“Сэтгүүлчид үдийн хоол, оройн зоог, үнэ төлбөргүй амралт, зугаалга, байр, машин, албан тушаал, эсвэл... аялах боломжийг алддаггүй”

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.8

4.8 Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчид болон бусад ажилтны цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл зохистой түвшинд байдаг.


Хэвлэл мэдээллийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг хүмүүс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж, байгууллагаас нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг. Илүү цагийн мөнгө авдаггүй. Сэтгүүлчдийн цалин, нийгмийн хамгааллын талаар ажил олгогчидтой хэлэлцээрт орж хөдөлмөрийн нөхцөл байдлыг сайжруулах Үйлдвэрчний Эвлэл хэвлэл мэдээллийн салбарт байхгүй гэж хэлж болно. Цалин хөлс бага байдаг нь сэтгүүлчид мэргэжилдээ үнэнч бус, авилгалаас татгалздаггүйн нэг гол шалтгаан болдог.

“Сэтгүүлчдийн цалин, нийгмийн хамгааллын талаар ажил олгогчидтой хэлэлцээр хийж нөхцөл байдлыг сайжруулах Үйлдвэрчний Эвлэл хэвлэл мэдээллийн салбарт байхгүй.”

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

1.9

4.9 Хэвлэл мэдээллийн ажилтнууд мэргэжил дээшлүүлэх, давтан суралцах боломжоор хангагдсан.

Монголд 17 их, дээд сургууль сэтгүүлч мэргэжлээр дээд боловсрол олгодог. Хэвлэл мэдээллийн салбарт сургалт, судалгаа эрхэлдэг төрийн бус байгууллага болох Хэвлэлийн Хүрээлэнд бакалаврын сургалтаас гадна сэтгүүлзүйн дээд курсийг зохион байгуулдаг. Тус байгууллагаас болон Глоб Интернэншл төрийн бус байгууллагаас ажиллаж буй сэтгүүлчдийн ур чадварыг сайжруулах сургалтуудыг ч санал болгоно. Сургалтын төлбөрийг аль болох бага байлгахыг

хичээдэг боловч төлбөрийн асуудал сэтгүүлчдэд бэрхшээл учруулах нь олонтаа. Нөгөө талаар редакциуд сэтгүүлчдээ сургалтад явуулах дургүй байдаг. Тэд мэргэжлийн сургалтын ач холбогдлыг бүрэн дүүрэн ойлгохгүй, эсхүл хүн хүчин дутмаг учир ажилтнаа чөлөөлөх боломжгүй байх нь түгээмэл. Сэтгүүлчид ч, тэдний удирдлага ч, редакцийн сургалтыг илүүд үзэх боловч хэвлэл мэдээллийн байгууллагууд ийм зүйлд мөнгө зарцуулах сонирхолгүй байдаг.


Гадаадад суралцах сонирхолтой олон сэтгүүлч байдаг боловч хэлний бэрхшээлээс болоод чаддаггүй. Орон нутгийнхан замын зардал, байрны асуудлаас үүдээд хотод болж буй сургалтад хамрагдах боломжгүй байдаг. Улаанбаатар хотод тус улсын 21 аймгаас бүгдээс нь хүн оролцуулсан сургалт хийхийн тулд зөвхөн замын зардалд наад зах нь 5 сая төгрөг (3580 Ам доллар) зарцуулах хэрэгтэй болно. Орон нутагт ихэнхдээ суурь мэдээлэл өгөх сургалтууд л явагддаг. Удирдах түвшний олон хүн удирдлагын арга барил, сэтгүүлзүй, чөлөөт хэвлэлийн тухай ойлголт тааруу, манлайллын мэдлэг чадваргүй учир тэднийг сургах шаардлага хэрэгцээ мөн өндөр байна.

*“Хэвлэл
мэдээллийн
байгууллагууд
сургалтанд
мөнгө
зарцуулах
сонирхолгүй
байдаг.”*

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.8

4.10 Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчид болон бусад ажилтнууд үйлдвэрчний эвлэл/эсхүл мэргэжлийн холбоодын гишүүн бөгөөд эдгээр нь тэдний ашиг сонирхлыг үр өгөөжтэй хамгаалж чаддаг.

“өөрийн ашиг сонирхлыг хамгаалж, эзэмшигчидтэй хэлэлцээр хийх байгууллагыг нэн даруй бий болгох нь чухал шаардлагатай.”

Сэтгүүлчдийн эвлэл, Чөлөөт сэтгүүлчдийн холбоо, Сонины холбоо, Телевизүүдийн холбоо гэх зэрэг хэвлэл мэдээллийн салбарын олон эвсэл холбоо байдаг. Монголын Сэтгүүлчдийн Эвлэл нь социализмын үеэс уламжлагдаж ирсэн томоохон байгууллага боловч голцуу эзэд дарга нарыг төлөөлдөг учир ашиг сонирхлын зөрчилд баригддаг. Сонины болон Телевизүүдийн Холбоо нь хэвлэн нийтлэгч, өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалахын тулд байгуулагдсан эздийн холбоо учир сэтгүүлчдийн эрх ашигт үйлчилдэггүй. Үйлдвэрчний эвлэл байгуулж, сэтгүүлчдийн ашиг сонирхлыг хамгаалах оролдлого одоог хүртэл бүтэлгүйтэж ирсний нэг шалтгаан нь эзэд, хөрөнгө оруулагчдын


эсэргүүцэл байв. Харин МОНЦАМЭ болон МҮОНРТ-ийн эрх зүйн статус өөр учир эдгээр байгууллагад өөрийн гэсэн үйлдвэрчний эвлэл ажилладаг.

Сэтгүүлчид нэн даруй хүчээ нэгтгэж, өөрийн ашиг сонирхлыг хамгаалж, эзэмшигчидтэй хэлэлцээр хийх байгууллага байгуулах нэн чухал шаардлага байгааг хэлэлцүүлэгт оролцогчид тэмдэглэв.

ОНОО:

Хувийн үнэлгээ:

- 1 Шалгуурыг огт хангахгүй байна
- 2 Шалгуурын зөвхөн цөөн үзүүлэлтийг хангаж байна
- 3 Шалгуурыг зарим талаар хангаж байна
- 4 Шалгуурын ихэнх үзүүлэлтийг хангаж байна
- 5 Шалгуурыг бүхий л талаар хангаж байна



Дундаж оноо:

2.3

4 БҮЛГИЙН ДУНДАЖ ОНОО:

2.6

МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙДЛЫН ДУНДАЖ ОНОО:

2.9

Цаашид хэрхэх тухай асуултууд:

Монголын хэвлэл мэдээллийн салбарт сүүлийн гурван жилд ямар чухал эерэг өөрчлөлтүүд гарав? Эдгээр өөрчлөлтийн эзэн буюу шалтгаан нь хэн, юу байв?

- Уул уурхайн өсөлт нь хэвлэл мэдээллийн салбарын тоон өсөлтөд шууд бусаар эерэг нөлөө үзүүлж байна.
- Иргэдийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай ойлголт дээшилж, мэдээллийн хэрэгсэл иргэдэд үзэл бодол, байр сууриа илэрхийлэх илүү өргөн боломжийг бий болгож байна.
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн салбарт олон асуудал тулгамдаж буй хэдий ч хөдөөгийн мэдээллийн хэрэгслийн тоо олширч, хамрах хүрээ сайжирч байна.
- Монголд гадаадын том сэтгүүл, хэвлэл мэдээллийн байгууллага салбараа нээж байна.
- Интернэтийн хэрэглээ өсөж, Интернэтээр мэдээлэл хайх, хүлээн авах хандлага нэмэгдэж байна.
- Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз үндэстний цөөнхөд зориулсан хоёрдугаар сувгаа нээлээ.
- 2011 онд батлагдсан Мэдээллийн Ил Тод Байдал ба Мэдээлэл Авах Эрхийн Тухай хуулийг хэрэгжүүлэх тохиолдолд иргэдийн төрийн байгууллагаас мэдээлэл авах боломж нээгдэх нөхцөл үүсч байна.

Монголын хэвлэл мэдээллийн салбарт сүүлийн гурван жилд ямар сөрөг өөрчлөлтүүд гарав? Эдгээр өөрчлөлтийн эзэн буюу шалтгаан нь хэн, юу байв?

- Редакцийн хараат бус байдал, өөрийн зохицуулалтын тогтолцоо зэрэг тулгуур асуудлууд одоог хүртэл шийдэгдээгүй байна.
- Хэвлэл мэдээллийн удирдах ажилтан, эрхлэгчид эздийн өмнөөс сэтгүүлзүйн үйл ажиллагааг хянах хандлага түгээмэл байна. Хэвлэл

мэдээллийн хэрэгслийг ухуулга сурталчилгааны хэрэгсэл болгон ашиглах нь ихэсч байна.

- Улс төрчид сэтгүүлзүйд зүй бусаар шууд нөлөөлж, эрүүл өсөлт хөгжилд нь саад болж, мэргэжлийн хэм хэмжээг алдагдуулж байна.
- Сэтгүүлзүйн болон сурталчилгааны агуулгыг зааглан салгахгүй байгаагаас гадна хэвлэл мэдээллийн байгууллагууд төлбөртэй мэдээллийг сэтгүүлзүйн хэлбэрээр бэлтгэж түгээх нь улам бүр нэмэгдэж байна.
- Сэтгүүлчид идэвхгүй, үзэл бодол, улс төрийн хамаарлаар хуваагдмал учир мэргэжлийнхээ нийтлэг ашиг сонирхлын төлөө нэгдэж тэмцэх чадваргүй байна.
- Сэтгүүлч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөр, багшлах боловсон хүчин, сургалтын орчин нь хэвлэл мэдээллийн салбарын цаг үеийн хэрэгцээ шаардлагаас хоцорч байна.

Монголын хэвлэл, мэдээллийг хөгжүүлэхийн тулд цаашид хэрэгжүүлэх ажлын санал

- Хэвлэл мэдээллийн салбарт тулгамдаж буй асуудлын талаарх нийтлэг ойлголт, ардчиллын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан өөрийн зохицуулалтын үр дүнтэй, ил тод, Монголын нөхцөлд тохиромжтой тогтолцоог бүрдүүлэх.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрх, эрх чөлөөний амин чухал ач холбогдлыг иргэний нийгмийн байгууллагуудад ойлгуулан таниулж, хэвлэлийн эрх чөлөөг дэмжин хөгжүүлэх үйлсэд тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх.
- Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн ач холбогдлын талаарх Засгийн газрын ойлголтыг сайжруулж, дэмжлэг хүртэх лобби үйл ажиллагаа явуулах.
- Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг эргэн харж, МҮОНРТ-ийн засаглал буюу удирдлагын тогтолцоог сайжруулах.
- Нууц эх сурвалжийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох лобби хийх.
- Хувийн мэдээллийн хэрэгслийн эзэмшил харъяаллыг задлан шинжилж, шударга өрсөлдөөн, эзэмшлийн ил тод байдлыг баталгаажуулах хуулийн зохицуулалтыг сурталчилж, ил тод байдлын соёлыг бий болгох.

- Нийгмийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхахгүй байх, хүний эрхийг дээдэлж, үзэн ядалтыг дэвэргэхгүй байх, мэргэжлийн хэм хэмжээ, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сэтгүүлчдэд сургалт явуулах.
- Хэвлэл мэдээллийн удирдах ажилтнуудын сэтгүүлзүйн үндсэн зарчим, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, менежмент, манлайлал, хүний нөөцийн хөгжил, шударга өрсөлдөөний бодлого, ил тод байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.
- Сэтгүүлзүйн болон сурталчилгааны хэсгийг зааглан салгах, хариуцлагатай сэтгүүлзүйг хөгжүүлэхэд чиглэсэн бүтэц, зохион байгуулалтыг хэвлэл мэдээллийн байгууллагуудад бий болгож, редакцийн бүтцийг шинэчлэх ажлыг өрнүүлэх.
- Сэтгүүлзүйн чиглэлээр дээд боловсрол олгодог их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, чанарыг ажиллаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран сайжруулах.
- Сэтгүүлчид ардчилсан хэвлэл мэдээллийн үндсэн зарчмын талаарх нэгдмэл ойлголттой болж, нийтлэг ашиг сонирхлынхоо төлөө Үйлдвэрчний Эвлэл гэх зэргийн байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо нэгтгэхэд нь дэмжлэх үзүүлэх.
- Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын дунд нийтлэг үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс санал бодол, тулгамдаж буй асуудлаа байнга хэлэлцэх индэр бий болгох.

*Сонгино, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс
2012 оны 9 дүгээр сарын 14 - 16*

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Д. Цэрэнжав

Чөлөөт сэтгүүлч, судлаач

Б. Хүрэлцэцэг

“Нутгийн хамт олны хөгжлийн хөтөлбөр”-ийн зохицуулагч Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв

Ж. Батбаатар

МУБИС-ын сэтгүүлзүйн тэнхимийн эрхлэгч

Х. Наранжаргал

„Globe International” ТББ-ын тэргүүн

Д. Саранчимэг

МНН группын Хүний нөөц, ерөнхий зохицуулалтын газрын дарга, Хуульч

Д. Нарантуяа

News Agency, орлогч захирал

Д. Нарантуяа

МҮОНТВ-ийн “Нийгэм эдийн засаг” редакцийн сэтгүүлч

О. Хишигсүрэн

“RGB” Дархан- уул Радио-Телевизийн сэтгүүлч

Ө. Отгонбаатар

Шонхор ТВ-ийн захирал, сэтгүүлч

Хэлэлцүүлгийн хөтлөгч:

М. Мөнхмандах

Хэвлэлийн Хүрээлэнгийн гүйцэтгэх захирал

Редактор:

Л.Болормаа

„Mining Journal” сэтгүүлийн үүсгэн байгуулагч, ерөнхий редактор

Аман болон бичгийн орчуулагч:

3. Базаргүр

Хөтөлбөр хариуцсан захирал, ФЭС-Монгол

Ч. Оюунгэрэл

Хөтөлбөр хариуцсан ажилтан, ФЭС-Монгол

М. Тунгалагтуяа

Зөвлөх

Хендрик Буссик

**Бичвэрийн хянан тохиолдуулсан ФЭС Хэвлэл
мэдээллийн Азийн хөтөлбөрийн менежер,
редактор**

Марина Крамер

ХАВСРАЛТ

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой зарим хууль, журам

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

<http://www.legalinfo.mn/law/details/367>

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998 он

<http://www.legalinfo.mn/law/details/546>

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2005 он

<http://crc.gov.mn/file/law/laws/olonniiit.pdf>

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2011 он

<http://www.legalinfo.mn/law/details/374>

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” журам, 2011он

<http://crc.gov.mn/file/juram/crcvtjuram.pdf>

Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим. Монголын Сэтгүүлчдийн Эвлэл, 2012 он

fesmedia Asia

(ФЭС-гийн Азийн хэвлэл мэдээллийн төсөл)

Фридрих-Эбертийн Сангийн
Шри Ланка ба Малдив улсыг
Хариуцсан төлөөлөгчийн газар
Утас: +94 112502710/1

Майл хаяг: nora@fessrilanka.org

<http://www.fesmedia-asia.org/>

Фридрих-Эбертийн Сангийн

Монгол дахь төлөөлөгчийн газар

Төв шуудан ш/х 831

Улаанбаатар хот-210648 Монгол Улс

Утас: +976-11-312892

Факс: +976-11-312889

Майл хаяг: oyun@fesmongol.net

**FRIEDRICH
EBERT
STIFTUNG**



ISBN No. 978-99973-50-11-4